



**МОНГОЛЫН БИЧИЛ УУРХАЙН
НЭГДСЭН ДЭЭВЭР ХОЛБОО**

2021-оны ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

**Улаанбаатар хот
2021 он**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:

МХЕГ-Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	
БОАЖГ-Байгаль орчин аялал жуулчалын газар	
МБУНДХ- Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо	
ТББ-Төрийн бус байгууллага	
БУ-Бичил уурхай	
ТАХ-Төрийн албан хаагч	
ХАМО- Хувиараа ашигт малтмал олборлогч	

ГАРЧИГ:

БҮТЭЭГДЭХҮҮН-1: ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ	6
ҮЙЛ АЖИЛЛАГАА-1.1: ХОЛБООНЫ ӨДӨР ТУТМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ	7
ҮА: 1.1.1: Санхүүгийн тайлан мэдээ	7
ҮА: 1.1.2: Гишүүдийн татвар бүрдүүлэлт	7
ҮА: 1.1.3: Гарсан шийдвэр тогтоол, албан бичиг төлөвлөлт	8
БҮТЭЭГДЭХҮҮН 1-ИЙН ДҮГНЭЛТ ХЭСЭГ:	9
БҮТЭЭГДЭХҮҮН-2: СУРГАЛТ ХӨГЖИЛ ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ БА ХЯНАЛТ МОНИТОРИНГ	9
ҮА: 2.1: УДИРДЛАГА ГҮЙЦЭТГЭХ АЛБЫГ ЧАДВАХЖУУЛАХ ХӨТӨЛБӨР	9
ҮА: 2.1.1: Удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн шинээр сонгогдсон гишүүдийг чадвахжуулах	9
1. УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН	9
ҮА: 2.1.2: Дотоод албаны чадвахжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	10
1. ГҮЙЦЭТГЭХ АЛБАНААС ЗОХИОН БАЙГУУЛСАН УУЛЗАЛТУУД	10
ҮЙЛ АЖИЛЛАГАА: 2.2: БИЧИЛ УУРХАЙН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ГИШҮҮДИЙГ ЧАДВАХЖУУЛАХ, ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ	10
ҮА: 2.2.1: Хууль эрх зүйн 8 цагийн сургалт: +1) БУ-н журам, Холбогдох хууль эрх зүйн мэдлэг олгох, Нөхөрлөл, хоршоо түүний хууль эрх зүйн зохицуулалт ба хамтын ажиллагааны аргачлал,) хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллуулахын тулд хяналт, хариуцлагын механизмийг сайжруулах зорилгоор Экологийн цагдаагийн албатай хамтран ажиллах	11

1. БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ЖУРМЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	11
2. БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ЖУРМЫН ШИНЭЧЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ АЙМГИЙН ХОЛБООДУУДАЙ ХИЙСЭН ОНЛАЙН УУЛЗАЛТ	11
3. ХОВД АЙМГИЙН ХОЛБООНЫ ХҮСЭЛТЭЭР ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН СЭДВЭЭР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ.....	12
4. СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙГ ШИНЭЧЛЭН БАЙГУУЛАХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭВ.....	12
5. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХУЛД СУМЫН ТАХИЛГАТ ЛУСЫН БУЛАГ ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДЭД ОДООГИЙН БИЧИЛ УУРХАЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ ТАЛААРХ УУЛЗАЛТ.....	13
ҮА: 2.2.2: Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал эзэмших, төлөвлөгөө боловсруулах 16 цагийн сургалт зохион байгуулах. Экологийн боловсрол олгох чиглэлийн байгууллаас сургалтын хөтөлбөрт зочин багш урьж оролцуулах.....	13
1. “БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТИЙН СИСТЕМ” СУРГАЛТ, ГОВЬ-АЛТАЙ, ХОВД.....	14
2. “БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТИЙН СИСТЕМ” СУРГАЛТ, СЭЛЭНГЭ АЙМАГ	14
3. МӨНГӨН УСНЫ ТУХАЙ МИНАМАТАГИЙН КОНВЕНЦ БА БИЧИЛ УУРХАЙ СЭДЭВТ ОНЛАЙН СУРГАЛТ.....	15
ҮА: 2.2.3: Бичил уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн багц 40 цагийн сургалт зохион байгуулах. /зөвхөн ажил олгогчийн сургалт/	16
1. БИЧИЛ УУРХАЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮРЭМ, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ БАРИМТЛАХ ЗАРЧМААР ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДАД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ.....	16
ҮА: 2.2.4: Бизнесээ эхэл-бизнесээ хөгжүүл хөтөлбөрийн бизнес төсөл боловсруулах, хуримтлалын бүлэг байгуулах нийт 40 цагийн сургалт зохион байгуулах.....	16
1. ДЭЛХИЙН ЗӨН ОУБ-ЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БИЗНЕСЭЭ ЭХЭЛ СУРГАЛТ, СЭЛЭНГЭ АЙМАГ МАНДАЛ СУМ.....	16
2. ДЭЛХИЙН ЗӨН ОУБ-ЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БИЗНЕСЭЭ ЭХЭЛ СУРГАЛТ, БАЯНХОНГОР АЙМАГ БАЯНЦАГААН СУМ.....	17
ҮА: 2.2.5: Хүний эрх ба жендэрийн арга барил, жендэрт суурилсан төлөвлөлт, бодлогын дүн шинжилгээ хийх, сэдэвт 8 цагийн сургалтыг зохион байгуулах.....	18
1. ЖЕНДЭР БА ХҮНИЙ ЭРХИЙН ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ПЛАНЕТ ГОЛД ТӨСӨЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА.....	18
ҮЙЛ АЖИЛЛАГАА: 2.3: ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДЫГ ҮНЭЛЭХ, ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ ЧАДВАХЖУУЛАХ ХӨТӨЛБӨРТ ХАМРУУЛАХ, БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЭРЭМБЭ, АНГИЛАЛ АХИУЛАХ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ, 2020 ОНЫ ҮНЭЛГЭЭНИЙ 1-Р АНГИЛАЛД БАГТСАН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ХАМТРАН АЖИЛЛАХ.....	19
ҮА: 2.3.1: Үнэлгээний зөвлөмжийн дагуу аймгийн холбоодыг чадвахжуулах хөтөлбөрт хамруулах, үнэлгээнд оруулах, ангилал ахиулах үйлчилгээ үзүүлэх.....	19

1. НЭГДҮГЭЭР АНГИЛАЛД БАГТСАН АЙМГИЙН ХОЛБООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	19
ҮА: 2.3.2: Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын шинэчлэгдсэн хувилбарыг танилцуулах ажлын санал авах, 1-р ангилалд багтсан байгууллагуудаас санал авч, ажил гүйцэтгэх гэрээ байгуулах, хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх	20
1. АЙМГИЙН ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗОРИЛГООР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ	20
ҮЙЛ АЖИЛЛАГАА: 2.4: БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ МОНИТОРИНГ ХИЙХ	20
ҮА: 2.4.1: Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээний хэрэгжилтийн мониторинг хийх. Мониторингийн үр дүнг талуудад танилцуулах, үр нөлөөг сайжруулахад талуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах.....	20
1. БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭНД МОНИТОРИНГ ХИЙХ АЖЛЫГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨЛТ	20
ҮЙЛ АЖИЛЛАГАА: 2.5: ХУУЛЬ БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ.....	21
ҮА: 2.5.1: МБУНДХ-ны гишүүн бус ХАМО иргэдэд чиглэсэн зөвлөх үйлчилгээ, хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт зохион байгуулах. Экологийн цагдаагийн албатай тухайн газарт хамтран ажиллах ..	21
ҮЙЛ АЖИЛЛАГАА: 2.6: БИЧИЛ УУРХАЙН САЙН ТУРШЛАГЫГ ТҮГЭЭХ, НЭВТРҮҮЛЭХ ЗОРИЛГООР ТУРШЛАГА СУДЛАХ АЯЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ	22
ҮА: 2.6.1: Бичил уурхайн сайн туршлагыг түгээх, нутагшуулах зорилгоор Сэлэнгэ аймгийн Мандал сумын бичил уурхайн сайн туршлага/хэвтээ олборлолт, нөхөрлөлийн зохион байгуулалт, ТББ-ын үйл ажиллагаа, олборлолтын газрын зохион байгуулалт, суурьшлын бүс, түүний зохион байгуулалт, дотоод дүрэм, журам, гишүүдийн сахилга бат, Хуримтлалын бүлгийн үйл ажиллагаа/ судлах аялал зохион байгуулах. Аяллын хөтөлбөр, саналыг хүргүүлэн оролцогчдыг бүртгэлжүүлэх, зохион байгуулах	22
ҮЙЛ АЖИЛЛАГАА: 2.6: хамтын ажиллагааны хүрээнд хийж хэрэгжүүлсэн бусад үйл ажиллагаа ..	23
1. КАНАДЫН БРИТИШ КОЛУМБЫН ИХ СУРГУУЛЬ, ГЕРМАН МОНГОЛЫН ХАМТАРСАН АШИГТ МАЛТМАЛЫН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИАС “БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛД КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ” СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА.	23
2. ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС ЗАРЛАСАН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТЭТГЭЛЭГТ САНЛАА ХҮРГҮҮЛЖ, ТЭТГЭЛЭГТ ХАМРАГДАН, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА.	24
3. ХОВД АЙМГИЙН ХОЛБООНЫ ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВЧ, ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА.	25
4. НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ “ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ УУЛ УУРХАЙН КОМПАНИУДЫН ХУДАЛДАН АВАЛТЫН ИЛ ТОД БАЙДАЛ” СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОВ.....	25
5. МОНГОЛ УЛС ДАХЬ “БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХ” ХӨТӨЛБӨРИЙН ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦЛОО.	26
6. ӨМГӨӨЛЛИЙН ЮНАЙТЕД САММИТ ХХК-ТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА	27

7. “ЭРДЭС БАЯЛАГ – ЭМЭГТЭЙЧҮҮД ҮНДЭСНИЙ Ш ЧУУЛГАН”-Д ОРОЛЦЛОО	28
БҮТЭЭГДЭХҮҮН: 2-ИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ:	28
ҮЙЛ АЖИЛЛАГАА: 3.1: БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА	33
ҮА: 3.1.1: ОРОН НУТГИЙН БИЧИЛ УУРХАЙ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА	33
БҮТЭЭГДЭХҮҮН-3: БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТООН МЭДЭЭЛЭЛ:	35
БҮТЭЭГДЭХҮҮН-4: НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ	36
ҮЙЛ АЖИЛЛАГАА: 4.1: ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН САЛБАР, АЖИЛТНУУДАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА	36
ҮА: 4.1.1: Сэтгүүлчдэд чиглэсэн сургалт, уулзалт зохион байгуулах, тодорхой хэвлэл мэдээллийн байгууллагуудтай тогтмол хамтран ажиллах гэрээ байгуулан хамтран ажиллах замаар хариуцлагатай уул уурхайн сэтгүүлчдийн клубийг үүсгэн байгуулж сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын тодорхой хэсэгт бичил уурхайн салбарыг хүлээн зөвшөөрүүлэх, бичил уурхайн салбарын талаар эерэг мэдээ мэдээллүүдийг тогтмол олон нийтэд хүргэх	36
ҮЙЛ АЖИЛЛАГАА: 4.2: ОЛОН НИЙТ, ШИЙДВЭР ГАРГАГЧДАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА	38
ҮА: 4.2.1: Хэвлэлийн бага хурал зохион байгуулах, сонин, телевиз, нийгмийн сүлжээний сувгуудын контентүүдийг бэлтгэж, цацах, Нөлөөллийн аян зохион байгуулах, урлагийн контент бэлтгэж цацах, тэмдэглэлт өдрүүдээр үйл ажиллагаа зохион байгуулж мэдээлэх замаар олон нийт, орон нутгийн удирдлагууд, шийдвэр гаргагчдад бичил уурхайн салбарыг таниулах, ялгаатай үйл ажиллагааг ойлгуулах. Салбарын эерэг туршлагаудыг багтаасан танилцуулга гаргах	38
БҮТЭЭГДЭХҮҮН: 4-ИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ:	39
БҮТЭЭГДЭХҮҮН-5: БАЙГУУЛЛАГЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ	40
ҮЙЛ АЖИЛЛАГАА: 5.1: БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ, ХӨГЖҮҮЛЭХ	40
ҮА: 5.1.1: ASMНUB.MN Веб сайтын эрхийг шилжүүлэн авч, үргэлжлүүлэн хөтлөхийн зэрэгцээ хөгжүүлэлт хийж, санхүүгийн эх үүсвэр олж болох платформтой холбуулах. Хөгжүүлэлт хийх	40
ҮЙЛ АЖИЛЛАГАА: 5.2: ХАБ-ЫН АЛБАН ЁСНЫ СУРГАЛТЫН ЭРХ АВАХ, ТӨЛБӨРТЭЙ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРҮҮД ГАРГАХ	41
ҮА: 5.2.1: Албан ёсны сургалтын эрх авна. Энэ ажлын чиглэлээр мэргэшсэн хуулийн зөвлөхтэй үйлчилгээний гэрээ байгуулан ажиллана. Мөн зөвлөх үйлчилгээний болон ХАБ-ын сургалтын хөтөлбөр гаргах	41
Гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдал, галын аюулгүй ажиллагаа	42
ҮЙЛ АЖИЛЛАГАА: 5.3: ОНЛАЙН СУРГАЛТЫН ПЛАТФОРМ БИЙ БОЛГОХ	43
ҮА: 5.3.1: Байгууллагын цахим сайтыг сургалтын платформ чиглэлээр хөгжүүлэх	43
ҮЙЛ АЖИЛЛАГАА: 5.4: ДОНОР ХАНДИВЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭГ ӨРГӨТГӨХ, ШИНЭ ХАРИЛЦАГЧДЫГ БИЙ БОЛГОХ	44
ҮА: 5.4.1: Шинээр зарлагдсан боломжит төсөл хөтөлбөрүүдэд оролцох. Байгууллагын дотоодод хэрэглэх төслийн баримт бичгийн мастер загварыг хөгжүүлэх	44
БҮТЭЭГДЭХҮҮН: 5-ИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ:	45

БҮТЭЭГДЭХҮҮН-6: БАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭДЭХ АЖ АХУЙ, ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ	45
ҮЙЛ АЖИЛЛАГАА: 6.1: ХАБЭА-Н АЛБАН ЁСНЫ СУРГАЛТ ЯВУУЛАХ ЭРХ БҮХИЙ СУРГАЛТЫН ТӨВИЙГ АЖИЛЛУУЛАХ	46
ҮА: 6.1.1: Сургалтын төв ажиллуулах бизнес төсөл бичих	46
ҮЙЛ АЖИЛЛАГАА: 6.2: УУЛ УУРХАЙН ТОМООХОН КОМПАНИУДТАЙ ГУРВАЛ-САН ГЭРЭЭ БАЙГУУЛАН ХАМТРАН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ БОЛОМЖИЙГ СУДЛАХ	46
ҮА: 6.2.1: Бизнес төслийг боловсруулах. Дотоодын томоохон уул уурхайн компаниудтай гурвал-сан гэрээ байгуулан хамтран ажиллах бизнес саналыг тавих, удирдлагуудтай уулзалт хийх.	46
ҮЙЛ АЖИЛЛАГАА: 6.3: ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ЭКСПОРТЫН СУДАЛГАА ХИЙХ	47
ҮА: 6.3.1: Үнэт эдлэлийг экспортлох бизнесийн суурь судалгаа хийх	47
БҮТЭЭГДЭХҮҮН: 6-ИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ:	48
БҮТЭЭГДЭХҮҮН-8: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОСГОХ, ГАДААД БОЛОН ДОТООД ХАРИЛЦААГ ХӨГЖҮҮЛЭЛТ	49
ҮЙЛ АЖИЛЛАГАА:8.1: ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ, ӨРГӨЖҮҮЛЭХ	49
ҮА: 8.1.1: а) Хөрөнгө оруулагч байгууллагуудтай холбоотой гадаад харилцааны хүснэгт хөтөлж, онлайн хурал, мэйл харилцаа, мэндчилгээ, тайлагнал, асуумж, хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулах	49
б) Боломжит харилцагч байгууллагуудын судалгаа хийж бүртгэл хөтөлж, хамтын ажиллагааг эхлүүлэх зорилготой мэйл бичих, танилцуулга хийх, биечлэн болон онлайн уулзалт зохион байгуулах, МБУНДХ-г сурталчлан таниулах	49
ҮЙЛ АЖИЛЛАГАА: 8.3: ОЛОН УЛСЫН ПЛАТФОРМУУДАД ЭЛСЭХ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ	51
ҮА: 8.3.1: а) Дэлхийн банк, Solidaridad, Impact, PDAC, IGF, OECD, ADB, fundsforngo, twitter, linkedin бүхий том хэмжээний төслийн мэдээлэл агуулсан платформуудад бүртгүүлж тухай бүр мэдээлэл авч төсөл хөтөлбөр арга хэмжээнүүдийн мэдээлэл цаг алдалгүй авах	51
б) Төсөл хөтөлбөрүүдийн бүртгэл бүхий хүснэгт хөтөлж, үр дүнгийн шинжилгээ хийж эх үүсвэр, цаг хугацаа хүн хүчийг зөв зохистой хуваарилах.	51
в) Төслийн санал боловсруулах хувилбарууд хөгжүүлэх	51
БҮТЭЭГДЭХҮҮН: 8-ИЙН НЭГДСЭН ТООН МЭДЭЭЛЭЛ:	Error! Bookmark not defined.
ТАЙЛАНГИЙН ХУГАЦААНЫ ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДЫН НЭГДСЭН ТООН МЭДЭЭЛЭЛ:	55
БЭЛТГЭСЭН	55

БҮТЭЭГДЭХҮҮН-1: ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ

ҮЙЛ АЖИЛЛАГАА-1.1: ХОЛБООНЫ ӨДӨР ТУТМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**ҮА: 1.1.1: Санхүүгийн тайлан мэдээ****Огноо: 2021/01/01-06/30**

Үйл ажиллагаа: Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо ТББ нь тогтмол санхүүгийн тайлан мэдээ гаргаж, Монгол улсын санхүүгийн хууль тогтоомж, төрийн бус байгууллагын тухай хууль тогтоомж, дотоод санхүүгийн дүрэм, журам зэрэг холбогдох эрх зүйн баримт бичгийн хүрээнд зохион байгуулагддаг бөгөөд улирал, жилийн тайлан тэнцлийг холбогдох талуудад хүргүүлж, жил бүр санхүүгийн аудит тогтмол хийлгэж байна.

- Энэ жилийн эхний улиралд, өнгөрдөг оны жилийн эцсийн санхүүгийн тайлан эцэслэн гаргаж Баянгол дүүргийн санхүүгийн хэлтэс цахимаар илгээсэн. Санхүүгийн тайланд аудит хийлгэхээр Гроут финанс аудит ХХК сонгон аудитаар орохоор гэрээ байгуулав.
- Татварын хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор 2020 оны 4-р улиралд : ТТ-11 буюу Цалин хөдөлмөр хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан,
- ТТ-02 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан,
- ТТ- 12 Суутган төлөгчийн хувь бүгд олгосон орлогод ногдуулан суутган албан татварын тайлан,
- VSHT-01 Үнэ шилжилтийн жилийн ажил гүйлгээний тайлангуудыг гарган цахимаар татварын албанд илгээсэн.
- Нийгмийн даатгалын жилийн эцсийн тайланг тушаан тухайн байгууллагатай тооцоо нийлэв.
- 2021 оны 1,2 улирлын Цалин хөдөлмөр хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан цахимаар тушааж баталгаажуулав.

Үр дүн: Санхүүгийн тайлан, тэнцэл тогтмол хийгдэж, санхүүжүүлэгч байгууллага болон гишүүдийнхээ өмнө нээлттэй ил тод тайлагнадаг. Улмаар холбогдох эрх зүйн баримт бичиг, дотоод дүрэм журмын хүрээнд санхүүгийн тайлан тэнцлийн хуулийн дагуу гарган илгээж байна.

ҮА: 1.1.2: Гишүүдийн татвар бүрдүүлэлт**Огноо: 2021/01/01-06/30**

Үйл ажиллагаа: 2019 оны 9 дүгээр сараас хойш бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа аажимдаа хумигдсан, энэ нь бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд авах арга хэмжээ буюу Засгийн Газрын 355-р тогтоолоор шинээр гэрээ байгуулах, газрын дүгнэлт гаргах асуудалд хориг тавьсан мөн 151-р тогтоолоор батлагдсан

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам шинэчлэгдэн гарах гэж байгаатай холбогдуулан манай гишүүд хүлээлтийн байдалтай өнөөг хүрч байгаа тул, санхүүгийн чадамж буурч гишүүдээс орж ирэх татвар багассан байгаа юм. Одоогоор 2021 оны эхний хагас жилд төвлөрсөн татварын хэмжээг ийнхүү харуулав.

Хэнээс	Мөнгөн дүн	тайлбар
Өмнөговь аймгийн холбоо	3,600,000	Бүтэн жилийн татвар бүрэн төлөгдсөн
Говь-алтай аймгийн холбоо	900,000	1-р улирлын татвар
Баянхонгор аймгийн холбоо	900,000	1-р улирлын татвар
Ховд аймгийн холбоо	900,000	1-р улирлын татвар
Сэлэнгэ аймгийн холбоо	300,000	1-р сарын татвар
Нийт	6,600,000	

Үр дүн: Гишүүдийн татвар төвлөрүүлэлт орон нутгийн бичил уурхайн олборлолтын үйл ажиллагаатай шууд холбоотой төдийгүй улс орон даяар үүсээд байгаа ковид цар тахлын нөлөөллөөс татвар төвлөрүүлэлт дутмаг байгаатай холбоотойгоор өнгөрсөн он буюу 2020 онд гишүүдийн татварыг 100% чөлөөлсөн шийдвэрийг удирдах зөвлөлөөс гаргасан юм. Энэ 2021 оны хувьд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын өөрчлөлт, шинэчилсэн журам хэрэгжиж үйл ажиллагаа жигдэрсэн тохиолдолд татвар хэвийн болох магадлалтай байна. Одоогийн байдлаар 4 аймгаас орж ирсэн нийт татвар 6,600,000 төгрөг төвлөрсөн байна.

ҮА: 1.1.3: ГАРСАН ШИЙДВЭР ТОГТООЛ, АЛБАН БИЧИГ ТӨЛӨВЛӨЛТ

Огноо: 2021/01/01-06/30

Үйл ажиллагаа: МБУНДХ-ноос 2021 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар 21 албан бичгийн төлөвлөн хүргүүлсэн бөгөөд бичил уурхайн байгууллагын хамтын ажиллагаа, хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хүрээнд тус албан бичиг төлөвлөгдсөн байна. Нөлөөллийн шинж чанар агуулсан 17 албан бичгийг бичил уурхайн салбарын хууль эрх зүйн орчныг хэвээр нь үлдээх зорилго агуулсан ба журмын шинэчлэлтэд оруулах санлыг тусгуулах талаар мэдээлэл агуулсан албан бичгүүд төлөвлөн хүргүүлээд байна.

- Мөн хамтран ажилладаг байгууллагуудаас болон дээрх албан бичгийн хариу нийт 7 албан бичиг ирсэнийг холбогдох мэргэжилтнүүд, тэргүүн, гүйцэтгэх захиралд хүргүүлэн, бүртгэлийн дэвтэрт бүртгэн, холбогдох асуудлуудаар авах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үр дүн: Холбогдох талуудтай хамтын ажиллагаа бий болсон, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд өөрчлөлт оруулах, ажлын хэсгийг гишүүд болон яам тамгын газруудыг бичил уурхайн салбарын мэдээллээр хангах зорилго агуулсан албан бичгүүдийг төлөвлөн хүргүүлснээр нөлөөлөл үзүүлэн ажиллаж байна. Нийт явуулсан албан бичиг 17, ирсэн албан бичиг 7 байна.

БҮТЭЭГДЭХҮҮН 1-ИЙН ДҮГНЭЛТ ХЭСЭГ:

- Бүтээгдэхүүн 1-ийн хүрээнд 3 үйл ажиллагааг дэлгэрэнгүй тайлагнасан ба холбогдох дүгнэлт хэсгийг доор танилцуулав.
- Санхүүгийн тайлан, тэнцэл тогтмол хийгдэж, санхүүжүүлэгч байгууллага болон гишүүдийнхээ өмнө нээлттэй ил тод тайлагнадаг. Улмаар холбогдох эрх зүйн баримт бичиг, дотоод дүрэм журмын хүрээнд санхүүгийн тайлан тэнцлийн хуулийн дагуу гарган илгээж байна.
- Гишүүдийн татвар төвлөрүүлэлт орон нутгийн бичил уурхайн олборлолтын үйл ажиллагаатай шууд холбоотой төдийгүй улс орон даяар үүсээд байгаа ковид цар тахлын нөлөөллөөс татвар төвлөрүүлэлт дутмаг байгаатай холбоотойгоор өнгөрсөн он буюу 2020 онд гишүүдийн татварыг 100% чөлөөлсөн шийдвэрийг удирдах зөвлөлөөс гаргасан юм. Энэ 2021 оны хувьд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын өөрчлөлт, шинэчилсэн журам хэрэгжиж үйл ажиллагаа жигдэрсэн тохиолдолд татвар хэвийн болох магадлалтай байна. Одоогийн байдлаар 4 аймгаас орж ирсэн нийт татвар 6,600,000 төгрөг төвлөрсөн байна.
- Мөн ирсэн явсан албан бичиг төлөвлөлтийг дэвтэр бүртгэн холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлэн, авах арга хэмжээ, хийж хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн ажиллаж байна. Нөлөөллийн шинж чанар агуулсан албан бичгүүдийг талуудад хүргэснээр бичил уурхайн салбарыг таниулахад нөлөөлсөн үр дүнгүүд гарсаар байна.

БҮТЭЭГДЭХҮҮН-2: СУРГАЛТ ХӨГЖИЛ ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ БА ХЯНАЛТ МОНИТОРИНГ

ҮА: 2.1: УДИРДЛАГА ГҮЙЦЭТГЭХ АЛБЫГ ЧАДВАХЖУУЛАХ ХӨТӨЛБӨР

ҮА: 2.1.1: УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ШИНЭЭР СОНГОГДСОН ГИШҮҮДИЙГ ЧАДВАХЖУУЛАХ


1. УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН

Огноо: 2021/02/28

Үйл ажиллагаа: МБУНДХолбооны удирдах зөвлөлийн ээлжит хурал хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцлээ. Үүнд:

МБУНДХ-ны 2020 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх.

МБУНДХ-ны 2021 оны төсөв, төлөвлөгөөтэй танилцаж, хэлэлцэх.



- МБУНДХ-ны гишүүн байгууллагууд болох 13 аймгийн холбоонд хийсэн хөндлөнгийн байгууллагын үнэлгээтэй танилцах.
- МБУНДХ-ны бүх гишүүдийн хурлын тов болон дүрмийн өөрчлөлтийн талаар хэлэлцэн тодорхой шийдвэрүүдийг гаргалаа. Удирдах зөвлөлийн гишүүд гүйцэтгэх албаны ажлын гүйцэтгэлд сэтгэлд хангалуун байгаа бөгөөд шилэн ил тод явж байгааг олон улсын нэр хүндтэй аудитын байгууллагын дүгнэлтээр жил бүр баталгаажин олон мянган гишүүдийнхээ өмнө хариуцлагатай ажлуудыг өрнүүлсэнд талархал илэрхийлсэн юм. Мөн цаашид анхаарч ажиллах зөвлөмжүүдээ ч харамгүй өгч ажиллалаа. Хуралд МБУНДХ-ны тэргүүн Л.Дэлгэрбаяр, гишүүн Т.Төртогтох, А.Алтанхуяг, М.Цэцэгээ, Ч.Мядагдадам нар оролцлоо.

Үр дүн: Удирдах зөвлөлийн гишүүдийн хуралдаан болж, 5 гишүүн оролцож, ирц 80%-тай байсан ба гүйцэтгэх албаны үйл ажиллагааны ажлын тайлантай танилцаж, 2021 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй танилцаж, санал өгөв. Мөн гишүүн байгууллагуудыг эрэмбэлэх, үнэлгээг хийсэн байгууллагаас гаргасан тайлантай танилцаж холбоодын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотойгоор гишүүн байгууллагуудтай ажиллах, эрэмбэ ахиулахад дэмжлэг үзүүлэх талаар гүйцэтгэх албанд үүрэг болгов. Удирдах зөвлөлийн хуралд эрэгтэй-3, эмэгтэй-2 хамрагдсан.

ҮА: 2.1.2: ДОТООД АЛБАНЫ ЧАДВАХЖУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ.

1. ГҮЙЦЭТГЭХ АЛБАНААС ЗОХИОН БАЙГУУЛСАН УУЛЗАЛТУУД

Огноо: 2021/06/30

Үйл ажиллагаа: Гүйцэтгэх албаны ажилтнууд дотоод хурал, уулзалтуудыг тогтмол 7 хоног бүр зохион байгуулж, өөрсдийн хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудаа дэлгэрэнгүй тайлбарлан, ажлын гүйцэтгэл, хийхээр төлөвлөсөн ажлын явцаа танилцуулахын зэрэгцээ бусдадаа мэдээлэл өгөх, харилцан мэдээлэл солилцох зорилгоор хийгдэж тогтмол хийж хэвшсэн.

Үр дүн: Энэхүү уулзалт, хурал нь дотоод ажлын уялдаа холбоог сайжруулахын зэрэгцээ, ажлын үр дүнг нэмэгдүүлэх, улмаар ажлыг тасралтгүй зохион байгуулах, цаг хугацаанд нь хэрэгжүүлэх чухал ач холбогдолтой байлаа. Мөн гүйцэтгэх албаны дотоод хурлын тэмдэглэл хөтлөн, ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцож ажиллахад чухал ач холбогдолтой байлаа. Дотоод хуралд тогтмол 5 хүн хамрагдсан. Үүнээс эрэгтэй-1, эмэгтэй-4 байна.


ҮЙЛ АЖИЛЛАГАА: 2.2: БИЧИЛ УУРХАЙН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ГИШҮҮДИЙГ ЧАДВАХЖУУЛАХ, ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ.

ҮА: 2.2.1: Хууль эрх зүйн 8 цагийн сургалт: +1) БУ-н журам, Холбогдох хууль эрх зүйн мэдлэг олгох, Нөхөрлөл, хоршоо түүний хууль эрх зүйн зохицуулалт ба хамтын ажиллагааны аргачлал,) хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллуулахын тулд хяналт, хариуцлагын механизмийг сайжруулах зорилгоор Экологийн цагдаагийн албатай хамтран ажиллах

1. БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ЖУРМЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА.

Огноо: 2021/03/10

Үйл ажиллагаа: Энэ ажлын хүрээнд 2017 оны 151-р тогтоол “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын өөрчлөлт, шинэчлэлттэй холбоотойгоор гишүүдэд чиглэсэн сургалт зөвлөх үйлчилгээ үзүүлээгүй хэдий ч, тус журмын ажлын хэсгийн гишүүнээр 2 хүн ажилласан, үүнд Гүйцэтгэх захирал Г.Мөнхцэцэг, Орон нутаг хариуцсан зөвлөх О.Цэцэгмаа нар ажилласан.



- Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооноос ажлын хэсэгт санал хүргүүлсэн ба бичил уурхай эрхлэгч гишүүдээс тодорхой саналууд авч, нэгтгэн боловсруулж хүргүүлсэн. Мөн ажлын хэсэг, аймгуудаас санал авах ажиллагааг зохион байгуулсан ба зургадугаар сарын байдлаар яамдуудаас санал авах ажиллагаа явагдаж байна.

Үр дүн: Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд өөрчлөлт оруулах төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээний танилцуулга бэлтгэн хүргүүлсэн нь салбарын хэмжээнд оруулсан саналаа бататгах, гол үндэслэл болох юм. Ажлын хэсгийн хуралдаан 15 үүнээс эрэгтэй-10, эмэгтэй-5 байна.

2. БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ЖУРМЫН ШИНЭЧЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ АЙМГИЙН ХОЛБООДУУДАЙ ХИЙСЭН ОНЛАЙН УУЛЗАЛТ

Огноо: 2021/01/05

Үйл ажиллагаа: Монгол Улсын засгийн газрын 2017 оны 151-р тогтоолоор батлагдсан бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг шинэчлэх ажлын хэсгээс гаргасан шийдвэрийн дагуу бичил уурхай бүхий аймгуудаас санал авах ажиллагааг зохион байгуулж байгаатай холбогдуулан яаралтай хуралдуулав.



- Аймгийн холбоодын удирдлагууд өөрсдийн байр суурь, орон нутгийн болон олборлолтын нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байгаагаа илэрхийлж, санал солилцон нэгдсэн санал өгөх ажиллагааг зохион байгуулж, аймаг бүр санал өгөх ажлыг шуурхай зохион байгуулахаар тогтов.

Үр дүн: Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг шинэчлэх зорилгоор бичил уурхай бүхий орон нутгуудаас авч байгаа саналд идэвхтэй оролцон саналаа хүргүүлэх талаар нэгдсэн ойлголттой болсон. Тус уулзалтанд аймгийн холбоод, түүний гишүүд нийт 24 хүн хамрагдсан үүнээс эрэгтэй-14, эмэгтэй-10 байна.

3. ХОВД АЙМГИЙН ХОЛБООНЫ ХҮСЭЛТЭЭР ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН СЭДВЭЭР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

Огноо: 2021/01/01

Үйл ажиллагаа: Ховд аймгийн Алтан уулын эздийн холбоо ТББ-ийн гишүүдийн хүсэлтээр онлайн сургалтыг зохион байгуулав. Тус сургалтыг бичил уурхайн хууль эрх зүйн орчин ба орон нутагт тулгамдаж буй асуудлаар зөвлөн туслах үйлчилгээг удаа дараа үзүүлэв.

- Газрын хүсэлт гаргахад бүрдүүлэх материалууд болон нөхөрлөл байгуулахад анхаарах тухай саналууд гарч байлаа. Холбогдох саналууд болон бичил уурхайн хууль эрх зүйн орчны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж, асуултуудад хариулт өгөх зарчмаар явагдлаа.



Үр дүн: Ховд аймгийн холбооны гишүүд бичил уурхайн хууль эрх зүйн орчин, зохион байгуулалтын тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэх мэдлэгээ нэмэгдүүлсэн. Хамтын хөдөлмөрийн үр шимийг хүртэх, түүнээс гарах ашгийг жигд хүртэх боломж, нэмэлт орлого олох, бичил уурхайн салбараас аажмаар өөр салбарт шилжих, бизнес эрхлэх боломжуудын талаар мэдлэг олгож, мэдээлэл өгсөн. Тус хуралд 10 нөхөрлөлийн ахлаг оролцсон үүнээс эмэгтэй-1, эрэгтэй-9 байна.

4. СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙГ ШИНЭЧЛЭН БАЙГУУЛАХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭВ.

Огноо: 2021/01/02

Үйл ажиллагаа: Сэлэнгэ аймгийн холбооны тэргүүлэгчид яаралтай асуудлаар онлайнаар хуралдав. Хурлын үйл ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл өгөх, техникийн тусламж үзүүлэх, зөвлөх, чиглүүлэгчээр оролцов.

- Хурлаар Сэлэнгэ аймгийн холбооны ажлыг эрчимжүүлэх, бүх гишүүдийн хурлыг зохион байгуулах үндсэн зорилгоор санал гарч дараах шийдвэрт хүрлээ. Бүх гишүүдийн хурлыг зохион байгуулахад ажлын хэсэг байгууллаа. Ажлын хэсэгт сум, тосгон бүрээс төлөөлөл оруулж ажиллуулах санал гарч, дэмжигдлээ. Тус ажлын хэсэг 11 гишүүнтэй байгуулагдав.



Үр дүн: Сэлэнгэ аймгийн холбооны үйл ажиллагааг идэвхжүүлэх, бүх гишүүдийн оролцоог хангах, ажлын хэсэг амжилттай зохион байгуулагдлаа. Холбогдох эрх зүйн мэдээ мэдээлэл өгч, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэн ажилласан. Тус хуралд 11 гишүүн хамрагдсан үүнээс эрэгтэй-6, эмэгтэй-5,

5. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХУЛД СУМЫН ТАХИЛГАТ ЛУСЫН БУЛАГ ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДЭД ОДООГИЙН БИЧИЛ УУРХАЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ ТАЛААРХ УУЛЗАЛТ.

Огноо: 2021/02/15

Үйл ажиллагаа: Дундговь аймгийн Хулд суманд үйл ажиллагаа явуулж буй “Тахилгат лусын булаг” ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүдийн хүсэлтийн дагуу тус хуралд онлайнаар оролцож бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам болон одоогийн нөхцөл байдал, журмын хэрэгжилт, тулгамдаж буй асуудлууд, мониторингийн дүгнэлтийг танилцуулж, цаашид анхаарах асуудлуудаар мэдээлэл хийж, хамтран санал солилцлоо.



Үр дүн: Тахилгат лусын булаг ТББ-ын удирдлагууд мэдээллээр хангагдсан ба бичил уурхайн салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаандаа тулгамдаж буй асуудлуудаар нэгдсэн мэдээлэл авсан. Тус хуралд удирдах зөвлөлийн 7 гишүүн хамрагдсан. Үүнээс эмэгтэй-3, эрэгтэй-4,

ҮА: 2.2.2: Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал эзэмших, төлөвлөгөө боловсруулах 16 цагийн сургалт зохион байгуулах. Экологийн боловсрол олгох чиглэлийн байгууллаас сургалтын хөтөлбөрт зочин багш урьж оролцуулах

1. “БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТИЙН СИСТЕМ” СУРГАЛТ, ГОВЬ-АЛТАЙ, ХОВД

Огноо: 2021/05/27

Үйл ажиллагаа: 2021 оны 5-р сарын 27-ны өдөр Говь-Алтай, Ховд аймгуудын БОАЖГ, Ховд аймгийн Булган сумын МХЕГ, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын БОАЖГ мөн Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо болон planetGOLD Монгол төсөл хамтран “Байгаль орчин, нийгмийн менежментийн систем” сэдэвт цахим сургалтыг амжилттай зохион байгууллаа. Сургалтад Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Ховд аймаг, Булган сум, Алтай сумын холбогдох төрийн байгууллагуудын албан хаагчид, бичил уурхайн байгууллагын төлөөлөл, нийт 34 хүн хамрагдлаа.



- Сургалтын үеэр бичил уурхайтай холбоотой байгаль орчны хууль, журмууд, алтны бичил уурхай дахь нөхөн сэргээлтийн хэрэгжилт болон тулгамдаж буй асуудлууд, төслийн хүрээнд хийгдсэн бичил уурхай нөхөн сэргээлтийн болон байгаль орчны асуудлууд, Ховд болон Говь-Алтай аймгуудын нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт болон хяналт, Байгаль орчин нийгмийн менежментийн систем, Сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх талаар мэдээлэл өглөө. Мөн орон нутгуудад байгаль орчны тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх замууд болон төсөв бий болгох талаар хэлэлцүүлэг явагдав.

Үр дүн: Бичил уурхай дахь өнөөгийн байгаль орчны хууль, журам, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар оролцогчдын ойлголт болон мэдлэг сайжирсан. Сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон бичил уурхайчдын оролцооны талаарх мэдлэг сайжирсан. Сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний загварыг тухайн орон нутаг дахь алтны бичил уурхай нөхцөл байдалтай уялдуулан боловсруулсан. Орон нутгийн хамтын ажиллагаа, бичил уурхайн нөхөн сэргээлтийн үр дүн, ач холбогдол, төлөвлөлтийн үр дүн, зэрэг талууд мэдлэгээ нэмэгдүүлсэн.

2. “БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТИЙН СИСТЕМ” СУРГАЛТ, СЭЛЭНГЭ АЙМАГ

Огноо: 2021/06/24

Үйл ажиллагаа: 2021 оны 6-р сарын 24-ны өдөр Сэлэнгэ аймгийн БОАЖГ, Баянгол, Мандал сумдын ЗДТГ, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо болон planetGOLD Монгол төсөл хамтран “Байгаль орчин, нийгмийн менежментийн систем” сэдэвт цахим сургалтыг амжилттай зохион байгууллаа.



- Сургалтад Сэлэнгэ аймаг, Баянгол сум, Мандал сум, Түнхэл тосгоны холбогдох төрийн байгууллагуудын албан хаагчид, бичил уурхайн байгууллагын төлөөлөл, нийт 23 хүн хамрагдлаа.
- Сургалтын үеэр бичил уурхайтай холбоотой байгаль орчны хууль, журмууд, алтны бичил уурхай дахь нөхөн сэргээлтийн хэрэгжилт болон тулгамдаж буй асуудлууд, орон нутгуудад хийгдсэн бичил уурхай нөхөн сэргээлтийн болон байгаль орчны асуудлууд, Сэлэнгэ аймгийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт болон хяналт, Байгаль орчин нийгмийн менежментийн систем, Сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх талаар мэдээлэл өглөө. Мөн сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрхэн боловсруулах, хэрэгжүүлэх талаар хэлэлцүүлэг явагдаж, сумын түвшинд байгаль орчны тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх замууд болон төсвийн талаар багууд хэлэлцэв.

Үр дүн: Байгаль орчин, нийгмийн менежментийн систем сургалтыг Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол сумдын хэмжээнд зохион байгуулсан бөгөөд тус сургалтанд оролцогчдод алтны бичил уурхайн салбарт тулгамдаж буй асуудлуудын талаар танилцуулж оролцов.

3. МӨНГӨН УСНЫ ТУХАЙ МИНАМАТАГИЙН КОНВЕНЦ БА БИЧИЛ УУРХАЙ СЭДЭВТ ОНЛАЙН СУРГАЛТ

Огноо: 2021/03/17

Үйл ажиллагаа: Мөнгөн усны тухай минаматагийн конвенц ба бичил уурхай сэдэвт онлайн сургалтыг Говь-алтай, Ховд аймгийн хэмжээнд зохион байгуулахад оролцон, бичил уурхайн өнөөгийн байдал сэдвээр танилцуулга хийж оролцлоо.



- **Сургалтын зорилго нь:** Орон нутгийн төрийн байгууллагын албан хаагчид, олон нийтэд Минаматагийн Конвенц, Хавсралт “В”, бичил уурхайн үйл ажиллагаагаар алт олборлох талаарх 7-р зүйл болон Монгол Улсын Засгийн газрын хүлээсэн үүрэг, Үндэсний хөтөлбөрийн талаарх мэдлэг, мэдээллийг түгээх, мөнгөн усны хэрэглээний өнөөгийн байдал, бичил уурхайгаар алт олборлох үйл ажиллагаан дахь мөнгөн усны хэрэглээг зогсоох талаар орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгах, шийдвэрлэх боломжуудыг бий болгоход дэмжлэг үзүүлэх байлаа.

Үр дүн: Ийнхүү хамтын ажиллагааны хүрээнд алтны бичил уурхайн дахь мөнгөн усны хэрэглээг бууруулах, Минаматагийн конвенц, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд оролцогч талуудын мэдлэгийг нэмэгдүүлэх ач холбогдолтой сургалт болсон. Тус сургалтанд 24 үүнээс эрэгтэй-10, эмэгтэй-14

ҮА: 2.2.3: Бичил уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн багц 40 цагийн сургалт зохион байгуулах. /ЗӨВХӨН АЖИЛ ОЛГОГЧИЙН СУРГАЛТ/

1. БИЧИЛ УУРХАЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮРЭМ, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ БАРИМТЛАХ ЗАРЧМААР ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДАД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ.

Огноо: 2021/04/24

Үйл ажиллагаа: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтын хөтөлбөрийг гишүүн бичил уурхайн аймгийн холбоодод илгээж ажлын байранд ажиллахаасаа өмнө тус сургалтанд заавал хамрагдсан байх, бүх гишүүд бүрэн хамрагдах, гэдэг шаардлагуудыг хүргүүлж, нэн тэргүүнд ХАБ уриан дор аюулгүй ажлын байранд ажиллахыг гишүүддээ уриалж ажиллаж байна.

- Мөн энэхүү сургалтын чиглэлээр Планет голд төслийн зорилтод аймаг сумуудад тус сургалтыг зохион байгуулахаар хамтран ажиллаж байна.
- Одоогоор Говь-алтай аймагт үйл ажиллагаа явуулж буй Алтайн бичил уурхайчдын эв нэгдлийн холбооноос сургалт авах хүсэлтээ ирүүлснээр тус сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Үр дүн: Бичил уурхайн салбарт ажиллаж байгаа гишүүдийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангаж ажиллуулахын тулд мэдлэг олгох сургалтыг ажил эхлэхийн өмнө бүх гишүүдийг заавал хамруулахаар бичил уурхайн журамд санал өгсөн ба тогтмол зохион байгуулахаар ажиллаж байна.


ҮА: 2.2.4: БИЗНЕСЭЭ ЭХЭЛ-БИЗНЕСЭЭ ХӨГЖҮҮЛ ХӨТӨЛБӨРИЙН БИЗНЕС ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ХУРИМТЛАЛЫН БҮЛЭГ БАЙГУУЛАХ НИЙТ 40 ЦАГИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ.

1. ДЭЛХИЙН ЗӨН ОУБ-ЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БИЗНЕСЭЭ ЭХЭЛ СУРГАЛТ, СЭЛЭНГЭ АЙМАГ МАНДАЛ СУМ

Огноо: 2021.05.17-18

Үйл ажиллагаа: Сургалтыг онлайн зүүм апалкешин ашиглаж, 2 бүлэг болгон 2 өрөөнд хуваарилж сургалтыг зохион байгуулсан.

- Сургалтын эхэнд онлайн сургалтын үеийн дүрмийг танилцуулан, нээлт хийснээр албан ёсоор сургалт эхэлсэн.
- Сургалт нийт 2 өдөр 16 цагаар үргэлжилж, Бүлэг-1-ийг Бизнесээ эхэл-Бизнесээ хөгжүүл хөтөлбөрийн зөвлөх багш Д.Азбилэг хөтлөн явуулсан бол Бүлэг-2-ийг Бизнесээ эхэл-Бизнесээ хөгжүүл хөтөлбөрийн зөвлөх багш У.Золжаргал хөтлөн явуулсан.
- Сургалтыг илүү үр дүнтэй, ойлгомжтой болгох, сургалтанд оролцогч бүрийн оролцоог хангахын тулд хүн бүрийн өөрийнх нь үйлдвэрлэл үйлчилгээний санаан дээр нь тулгуурлан бизнес төслийн сургалтыг хөтлөн явуулсан.



Үр дүн: Оролцогчид бизнес санаагаа хэрэгжүүлэхэд, өөрт тулгамдаж буй асуудлаар зөрүүтэй ойлголтоо, багшаасаа асууж, мэдлэгээ бататгасан ба цаашид зөвлөх үйлчилгээ авах боломжтой болсон. Оролцогчдын гэр бүлийн бизнесийн мэдлэгийг жигд нэмэгдүүлснээр бизнесээ хамтдаа хөгжүүлэх боломж нэмэгдсэн. Гишүүн нэг бүрийн оролцоо гэр бүлийн бизнесийг хөгжүүлэх ямар чухал болохыг ойлгож хүлээн авсан.

Бизнесийнхээ үйл ажиллагааг өргөжүүлэх ямар боломж байгааг, орон нутгийн сан, ЖДҮ-ийг дэмжих сан, гадаад дотоод санхүүжилтийн эх үүсвэрийн талаар мэдлэгтэй болсон.

Үйлдвэрлэгчид буюу шууд худалдаачдын ялгаатай бизнес эрхлэлтийн жишээ бодлого, төлөвлөлт, өөрийн өртөг, шууд ашиг алдагдлыг тооцоолж сурсан.

Сургалт 2 бүлгээр 2 өрөөнд хичээллэсэн нь оролцогч нэг бүртэй харилцах, цаг зарцуулалтыг нэмэгдүүлж, бүлгээр, чөлөөтэй, ойр дотно суралцах боломжийг бүрдүүлсэн.

Дүгнэлт: Оролцогч тал буюу суралцагчид онлайн сургалтын давуу талтайг онцолсон, тухайн сургалтын хугацаанд гэр бүлээрээ сургалтанд хамрагдаж чадсан нь бидний гэр бүлийн бизнесийн мэдлэгийг зэрэг нэмэгдүүлсэн гэж үзсэн байлаа.

2. ДЭЛХИЙН ЗӨН ОУБ-ЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БИЗНЕСЭЭ ЭХЭЛ СУРГАЛТ, БАЯНХОНГОР АЙМАГ БАЯНЦАГААН СУМ

Огноо: 2021.05.24

Үйл ажиллагаа: Сургалтыг онлайн зүүм апалкешин ашиглаж, сургалтыг зохион байгуулсан. Сургалтын эхэнд онлайн сургалтын үеийн дүрмийг танилцуулан, нээлт хийснээр албан ёсоор сургалт эхэлсэн.

- Сургалт нийт 10 цаг үргэлжилж, 25 оролцогчтойгоор Бизнесээ эхэл хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдсан.
- Сургалтыг зөвлөх багш зөвлөх багш У.Золжаргал, сургагч багш С.Нямдаваа, Р.Түмэндэмбэрэл нар хөтлөн явуулсан.
- Сургалтын турш ирц, бүртгэлийг захиалагч тал хариуцсан ба фото зургаар баримтжуулсан.

- Оролцогч нарын бизнесийн санааг хөгжүүлэх чиглэлээр илүү анхаарсан, тухайлбал гутлын үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний өөрийн өртгийг тооцох аргачлалыг эзэмшүүлж, үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн дээр дадлага хийж тооцож үзсэн.
- Мөн гарын авлага материал ашиглалт, санал асуулгын хуудас хэвлэх, авах зохицуулалтыг захиалагч тал бүрэн хариуцсан нь сургалтыг үр дүнтэй явуулахад дэмжлэг болж чадлаа.

Үр дүн: Гутал үйлдвэрлэл эрхлэгчдийн хамтын хөдөлмөр эрхлэлтийг бий болгосноор гарах үр дүнд нөлөөлсөн. Гутлын үйлдвэрийн давуу тал болон сул тал, зах зээлийн хүрээг тэлэх, үйлдвэрлэлээ өргөжүүлэх талаар жишээнд тулгуурлан сургалтын тайлбарлан зохион байгуулсан нь оролцогчдод илүү ойрхон байлаа.

Үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний өөрийн өртөг тооцох аргачлалд суралцсан, өөрийн өртгийг тооцохгүйгээр ашиг алдагдал тооцох, төлөвлөх боломжгүй юм гэдийг оролцогчид ойлгосон.

Бизнес эрхлэгчид санхүүгээ зөв удирдах, хуримтлалын зарчим, ач тусыг ойлгож амьдралдаа хэвшүүлэх сэдлийг бий болгож идэвхжүүлсэн.

Дүгнэлт: Дэлхийн Зөн Монгол ОУБ тай хамтран Баянхонгор аймгийн Баянцагаан сумын гутал үйлдвэрлэлийг эрхэлж байгаа болон эрхлэх хүсэлтэй байгаа иргэдийн бизнес санааг хөгжүүлэх, үйлдвэрлэлийг өргөжүүлэхэд хэрэгцээт мэдээллээр хангаж, мэдлэг мэдээллийн дагуу хэрэгжүүлэлтэнд хөтлөх зорилгын дагуу сургалтыг зохион байгуулсан.

ҮА: 2.2.5: Хүний эрх ба жендэрийн арга барил, жендэрт суурилсан төлөвлөлт, бодлогын дүн шинжилгээ хийх, сэдэвт 8 цагийн сургалтыг зохион байгуулах

1. ЖЕНДЭР БА ХҮНИЙ ЭРХИЙН ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ПЛАНЕТ ГОЛД ТӨСӨЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА.

Огноо: 2021/03/20

Үйл ажиллагаа: Планет гол төслийн 2021 оны жилийн төлөвлөгөөтэй танилцан, хамтран хэрэгжүүлэх буюу бие даан хэрэгжүүлэх саналуудаа албан бичгээр хүргүүлсэн ба тодорхой ажлууд дээр хамтын ажиллагаатай явж байна.

- Ийнхүү хүний эрх ба жендэрийн сургалтын хөтөлбөр, сургалтын модуль, холбогдох материалуудыг хүргэн, санал солилцох хэмжээнд ажиллаж байна. Зургадугаар сарын байдлаар Жендерийн мэргэжилтэн ажиллаж эхэлсэнтэй холбоотойгоор сургалтын зохион байгуулах, сургагч багш бэлтгэх асуудлаар харилцан санал солилцох түвшинд байгаа ба энэ сарын 28, 30 нд сургагч багшийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөөд байна. Тус сургалтанд Говь-алтай, Ховд, Сэлэнгэ аймгийн

холбоод болон МБУНДХ-ны гүйцэтгэх алба, сургагч багш нар хамрагдах юм. Илүү дэлгэрэнгүйг сургалтын дараах тайлангаас харах боломжтой юм.

Үр дүн: Бичил уурхай бүхий орон нутгийн хэмжээнд бичил уурхай эрхлэгчид, төрийн албан хаагчид хоорондын хамтын ажиллагааны үр дүнг сайжруулах, бичил уурхайчдад чиглэсэн орон нутгаас гаргасан бодлогын баримт бичиг, дүрэм журам жендэрийн мэдрэмжтэй, жендерийн дүн шинжилгээ хийсэн байх, гэсэн асуудлуудыг орхигдуулахгүй авч явах зорилго агуулсан байхаар дээрх сургалтыг зохион байгуулах юм.

ҮЙЛ АЖИЛЛАГАА: 2.3: ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДЫГ ҮНЭЛЭХ, ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ ЧАДВАХЖУУЛАХ ХӨТӨЛБӨРТ ХАМРУУЛАХ, БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЭРЭМБЭ, АНГИЛАЛ АХИУЛАХ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ, 2020 ОНЫ ҮНЭЛГЭЭНИЙ 1-Р АНГИЛАЛД БАГТСАН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ХАМТРАН АЖИЛЛАХ.

ҮА: 2.3.1: Үнэлгээний зөвлөмжийн дагуу аймгийн холбоодыг чадвахжуулах хөтөлбөрт хамруулах, үнэлгээнд оруулах, ангилал ахиулах үйлчилгээ үзүүлэх

1. НЭГДҮГЭЭР АНГИЛАЛД БАГТСАН АЙМГИЙН ХОЛБООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Огноо: 2021/04/17

Үйл ажиллагаа: Өмнөговь, Говь-Алтай, Баянхонгор аймгууд 2020 онд хийгдсэн үнэлгээний байгууллагаас гарсан дүгнэлтээр тус аймгууд нэгдүгээр ангилалд багтсан тул үйл ажиллагааг нь дэмжиж иж бүрэн оёдлын цехүүдийг хүлээлгэн өглөө. Үүнд: шулуун оёдлын машин тус бүр 2, хэрээсний машин тус бүр 1, уурын индүү зэрэг оёдлын үйл ажиллагаа явуулахад хэрэгцээтэй тоног төхөөрөмж багтсан байна.



- Мөн үйл ажиллагааг нь дэмжиж, тус бүр хатуу оёдол, дотуур хувцас оёх зориулалт бүхий оёдлын машинууд, мод суулгацын нүх ухагч төхөөрөмж зэрэг худалдан авахад зориулж тус бүр 3 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.

Үр дүн: Нэгдүгээр ангилалд багтсан байгууллага нь Санхүүжилт авах, төсөл хэрэгжүүлэх бүрэн чадамжтай, бүх үйлчилгээнд хамрагдах боломжтой байгууллага гэсэн үзүүлэлтээр тус аймгийн холбоодууд үнэлэгдсэн тул үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна. Тус дэмжлэгийн хүрээнд аймгийн холбоодын тогтвортой ажиллах, санхүүгээ өөрсдөө босгох боломжтой болно гэж үзэж байна.

ҮА: 2.3.2: Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын шинэчлэгдсэн хувилбарыг танилцуулах ажлын санал авах, 1-р ангилалд багтсан байгууллагуудаас санал авч, ажил гүйцэтгэх гэрээ байгуулах, хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх

1. АЙМГИЙН ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗОРИЛГООР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ

Огноо: 2021/01/01

Үйл ажиллагаа: Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын ажлын хэсгийн санал, холбогдох яамдуудаас санал авах ажиллагаа явагдаж байгаа бөгөөд Засгийн Газрын хуралдаанаар оруулан батлуулах ажлыг хийж хэрэгжүүлж дууссаны дараа, тус журам бичил уурхайн салбарт хэрэгжиж эхлэх үед 1-р ангилалд багтсан аймгийн холбоод журмыг танилцуулах эрх зүйн сургалт зохион байгуулах ажлыг бие даан хэрэгжүүлэх боломжийг дэмжиж ажиллахаар төлөвлөв.

Үр дүн: Аймгийн холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд гишүүдийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэн, бие даан үйл ажиллагаа хэрэгжүүлэх, хүний нөөцөө чадвахжуулах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА: 2.4: БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ МОНИТОРИНГ ХИЙХ

ҮА: 2.4.1: Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээний хэрэгжилтийн мониторинг хийх. Мониторингийн үр дүнг талуудад танилцуулах, үр нөлөөг сайжруулахад талуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах.

1. БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭНД МОНИТОРИНГ ХИЙХ АЖЛЫГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨЛТ

Огноо: 2021/02/25

Үйл ажиллагаа: Нээлттэй нийгэм форумаас өнгөрсөн онд хэрэгжүүлсэн Уул уурхайн салбарын ид тод байдал “Бичил уурхайгаар ашигт малтмал ашиглах гэрээний хэрэгжилтийн мониторинг” хийх төслийн хүрээнд Төв Заамар, Сэлэнгэ аймгийн Мандал, Түнхэл, Ерөө, Бугант, Орхонтуул, Баянгол, Дундговь аймгийн Хулд, Өлзийт, Баянжаргалан, Гурвансайхан сумуудад үйл ажиллагаа явуулж байгаа бичил уурхайн байгууллагуудад мониторинг хийсэн.

- Тус мониторингоор нэлээдгүй зөрчлүүд илэрсэн тул түүнийг таслан зогсоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих механизмыг сайжруулах, бичил уурхайчдын хариуцлагыг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэн тус мониторингийн ажлыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөсөн юм. Мониторингоор илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зорилгоор танилцуулах уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулах хэрэгцээ шаардлага байгаа тул ирэх жилийн төлөвлөлтөнд холбогдох санхүүжилтийг тусгах.

Үр дүн: Бичил уурхайн салбарын үйл ажиллагааг бүхэлд нь сайжруулах, хариуцлагжуулхын тулд гэрээний хэрэгжилтийн хугацаанд мониторинг хийх, гэрээний талуудад үр дүнг танилцуулах, зөрчлийг арилгах, гэрээг дүгнэх хэрэгцээ шаардлагууд байгаа юм. Тус үйл ажиллагааг хэрэгжүүлсний дараагаар нийтэд танилцуулах ажлуудыг зохион байгуулж, цаашид жил бүр тогтмолжуулан зөрчлийг илрүүлэх, арилгах арга хэмжээг авч ажиллах юм.

ҮЙЛ АЖИЛЛАГАА: 2.5: ХУУЛЬ БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ

ҮА: 2.5.1: МБУНДХ-ны гишүүн бус ХАМО иргэдэд чиглэсэн зөвлөх үйлчилгээ, хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт зохион байгуулах. ЭКОЛОГИЙН ЦАГДААГИЙН АЛБАТАЙ ТУХАЙН ГАЗАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ

1. ХУУЛЬ БУС ХУВИАРАА АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОГЧ ИРГЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАСЛАН ЗОГСООХТОЙ ХОЛБООТОЙ ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Огноо: 2021/04/15

Үйл ажиллагаа: Азийн сангаас хэрэгжүүлж байгаа хууль бус ашигт малтмал эрхлэгчдийг бууруулах төслийн хүрээнд хуулийн зөвлөх З.Эрдэмтэй холбогдон бичил уурхайн салбарын хууль эрх зүйн орчин, түүний зохицуулалтуудын талаар мэдээлэл өгч хамтран ажиллаж байна. Манай байгууллагын зорилготой уялдсан тус үйл ажиллагааг дэмжиж ажиллахаа илэрхийлсэн бөгөөд, цаашид үндэсний хэмжээнд хууль бус үйл ажиллагааг бууруулахаар тодорхой ажлуудыг хамтран хэрэгжүүлэх юм.

- Мөн МБУНДХ-ны зүгээс хууль бус үйл ажиллагааг бууруулахад хувь нэмэр
- оруулахаар, хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллахаар Экологийн цагдаагийн байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан ажиллаж байна. Тус хамтын ажиллагааны хүрээнд аймгийн холбоод орон нутгийн Экологийн албатай хамтран ажиллаж байгаа бөгөөд байгалийн баялгийг сорчлон авах, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөө, үр дагаврыг бууруулах зорилгоор, хууль бус үйл ажиллагааг шуурхай мэдээлж, таслан зогсооход хамтран ажиллаж байна.



Үр дүн: Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Азийн сангаас хэрэгжүүлж байгаа хууль бус үйл ажиллагаатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд манай байгууллагаас хамтран ажиллах, тухайлбал бичил уурхайн салбарын хууль бус олборлолтын үйл ажиллагаатай хамтран тэмцэх, мэдсээр байж хууль бус үйл ажиллагаанд оролцогчдыг илрүүлснээр тэдний үйл ажиллагааг албажуулахад хамтран ажиллах юм.

ҮЙЛ АЖИЛЛАГАА: 2.6: БИЧИЛ УУРХАЙН САЙН ТУРШЛАГЫГ ТҮГЭЭХ, НЭВТРҮҮЛЭХ ЗОРИЛГООР ТУРШЛАГА СУДЛАХ АЯЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ

ҮА: 2.6.1: Бичил уурхайн сайн туршлагыг түгээх, нутагшуулах зорилгоор Сэлэнгэ аймгийн Мандал сумын бичил уурхайн сайн туршлага/ХЭВТЭЭ ОЛБОРЛОЛТ, НӨХӨРЛӨЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТББ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ОЛБОРЛОЛТЫН ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, СУУРЬШЛЫН БУС, ТҮҮНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ДОТООД ДҮРЭМ, ЖУРАМ, ГИШҮҮДИЙН САХИЛГА БАТ, ХУРИМТЛАЛЫН БҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА/ СУДЛАХ АЯЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ. АЯЛЛЫН ХӨТӨЛБӨР, САНАЛЫГ ХҮРГҮҮЛЭН ОРОЛЦОГЧДЫГ БҮРТГЭЛЖҮҮЛЭХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ

1. DELVE EXCHANGE PROJECT БИЧИЛ УУРХАЙЧДЫН ТУРШЛАГА, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ОЛОН УЛСЫН ТӨСӨЛ НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦЛОО.

Огноо: 2021/04/26

Үйл ажиллагаа: Дэлхийн Банкны санхүүжилтээр Австрали улсын Күенсландын Их Сургуулиас (The University of Queensland) хэрэгжүүлэх "Delve Exchange Project" олон улсын төслийн танилцуулгын нээлтийн онлайн хурал зохион байгуулагдлаа.



- Тус хуралд Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооны удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн гишүүд болон аймгийн холбоодын тэргүүн, гүйцэтгэх захирлууд, нөхөрлөлийн ахлагч нар болоод гүйцэтгэх алба, нийт 45 хүн бүртгүүлснээс 29 хүн оролцлоо. Уг төсөлд Африк, Латин Америкийн орнууд хамрагдаж байгаа бөгөөд Ази тивээс Монгол улс оролцож байгаагаараа онцлог байлаа.
- Энэхүү төслийн зорилго нь орон орны бичил уурхайчид бичил уурхай дахь сайн туршлага, мэдээллээ солилцох явдал бөгөөд төслийн хүрээнд бичил уурхайчдын сүлжээг бий болгох, форум уулзалтууд зохион байгуулах, сургалт явуулах зэрэг үйл ажиллагаанууд явагдах ба төслийн хугацаанд онлайн платформ ашиглалтад орсноор олон орны бичил уурхайчидтай туршлага, мэдээллээ солилцох боломжтой болох юм.

Үр дүн: Бичил уурхай бүхий улс орнуудын дунд Монгол улс тэргүүн сайн туршлагуудыг нэвтрүүлсэн, сайн жишээ болохуйц үйл ажиллагаа явуулдгаараа манай улсын бичил уурхайн салбараас хуваалцах зүйл ихээхэн байгаа тухай онцолсон юм. Мөн манай салбарт тулгамддаг хэдэн хэдэн асуудлаар асуулт асууж, цаашид үйл ажиллагаандаа бусад улс орны сайн туршлагыг нэвтрүүлж, нутагшуулахад анхаарахаа илэрхийлсэн юм.

ҮЙЛ АЖИЛЛАГАА: 2.6: ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. КАНАДЫН БРИТИШ КОЛУМБЫН ИХ СУРГУУЛЬ, GERMAN МОНГОЛЫН ХАМТАРСАН АШИГТ МАЛТМАЛЫН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИАС “БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛД КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛЛИЙН ” СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА.

Огноо: 2021/04/20

Үйл ажиллагаа: Канадын Бритиш Колумбын Их Сургууль, Герман Монголын хамтарсан ашигт малтмалын технологийн их сургуулиас “Бичил уурхай эрхлэгчдийн нийгэм эдийн засгийн байдалд КОВИД-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ” судалгааны үр дүнгийн танилцуулгын онлайн уулзалтуудыг удаа дараа зохион байгууллаа.



- Тус уулзалтанд судалгааны багийн гишүүд болон МБУНДХ-ны гүйцэтгэх алба болон аймгийн холбоод, түүний гишүүд, яам тамгын газар, холбогдох төрийн байгууллагуудын оролцоотой цахим уулзалтуудыг удаа дараа зохион байгуулж, зохион байгуулалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаа.

Үр дүн: Уг судалгааны үр дүнг танилцуулах цахим уулзалтуудад МБУНДХ-ны 13 аймгийн холбоодын гишүүд оролцов. Судалгааны багийн гишүүдийн танилцуулж буй судалгааны үр дүнд бичил уурхайн салбарт Ковид-19 цар тахал хэрхэн нөлөөлж буйг гаргаж ирснээр тэдний өрхийн болоод, улс орны эдийн засагт үзүүлж буй хувь нэмэр, амьдралын түвшин буурсан үзүүлэлттэй байгааг эрх барих, шийдвэр гаргах, холбогдох яам тамгын газарт танилцуулан цаашид анхаарах хэрэгтэй байгааг онцлов.

2. ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС ЗАРЛАСАН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТЭТГЭЛЭГТ САНЛАА ХҮРГҮҮЛЖ, ТЭТГЭЛЭГТ ХАМРАГДАН, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА.

Огноо: 2021/03/31

Үйл ажиллагаа: Сургалт зохион байгуулах гэрээ байгуулагдлаа. Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо нь Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллагаас зарласан Сургалт зохион байгуулах төслийн сонгон шалгаруулалтад амжилттай оролцож, 2021.03.31-ний өдөр талууд хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа.



- Тус гэрээний хүрээнд Дэлхийн зөнгөөс зохион байгуулах нийгмийн тустай үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллах мөн бизнес сургалт зохион байгуулах чиглэлээр 3 жилийн хугацаатай хамтран ажиллахаар боллоо. Бидний хамтын ажиллагааны хүрээнд үр шимийг хүртэгч талуудад эерэг өөрчлөлт бий болно гэдэгт гүнээ итгэж байна.

Үр дүн: Дэлхийн зөн Олон Улсын байгууллагаас зарласан тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан Бизнесээ эхэл сургалт зохион байгуулах хамтран ажиллах 3 жилийн гэрээ байгуулан. Гэрээний дагуу 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, гэрээг амжилттай дүгнэж байна.

3. ХОВД АЙМГИЙН ХОЛБООНЫ ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВЧ, ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА.

Огноо: 2021.05.19

Үйл ажиллагаа: Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоонд Ховд аймгийн “Алтайн Уулын Эзэд” ТББ нь албан ёсны гишүүнээр элсэж хамтран ажиллах гэрээ байгууллаа.




- Талууд нь гишүүн бичил уурхайчдынхаа нийтлэг эрх ашгийг хамгаалах, тэдгээрийг тогтвортой ажлын байртай, орлоготой, байгаль орчны болон нийгмийн хариуцлагатай бичил уурхайчин, бизнес эрхлэгч болгон төлөвшүүлэх, улмаар тэдний амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгоор хамтран ажиллах юм.

Үр дүн: Ховд аймагт бичил уурхайн аймгийн холбоо байгуулагдан үйл ажиллагаа явуулж байсан хэдий ч гишүүдийн оролцоо, итгэлцэл хамтын ажиллагаа суларснаас гишүүд аймгийн холбоогоо шинэчлэн байгуулж, удирдлагын бүтцийг өөрчлөн, сонгож үйл ажиллагааг нь эрчимжүүлэн ажилласантай холбоотойгоор Алтан уулын эзэд ТББ-ыг байгуулан, хамтын ажиллагаагаа эхлүүлсэн юм.

4. НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ “ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ УУЛ УУРХАЙН КОМПАНИУДЫН ХУДАЛДАН АВАЛТЫН ИЛ ТОД БАЙДАЛ” СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОВ.

Огноо: 2021/04/28

Үйл ажиллагаа: "ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ УУЛ УУРХАЙН КОМПАНИУДЫН ХУДАЛДАН АВАЛТЫН ИЛ ТОД БАЙДАЛ" судалгааны тайлангийн цахим хэлэлцүүлэгт МБУНДХ-ны Гүйцэтгэх албаныхан оролцлоо.



- Монгол Улсын төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн компанийн худалдан авалтын ил тод байдлыг нэмэгдүүлэхэд хууль тогтоомжийн хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох нь судалгааны зорилго юм.
- Энэхүү судалгаанд төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудыг хамруулсан бөгөөд хуулийн

этгээдийн төлөөлөл болох нийт 9 компанийг захиалагч талтай хамтран сонгож, худалдан авах ажиллагааны ил тод байдлын талаар хуулиар хүлээсэн үүрэг, түүний хэрэгжилтийг хэмжих шалгуурыг Шилэн дансны тухай хууль болон дагалдах журамд заасан үзүүлэлтээр гаргаж, хэрэгжилтийг үнэлсэн байна.

Үр дүн: Нээлттэй нийгэм форум байгууллагатай хамтран ажиллаж байгаатай холбогдуулан тус байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцоотой явж, судалгааны тайлангийн цахим хэлэлцүүлэгт оролцож, хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай танилцав.

5. МОНГОЛ УЛС ДАХЬ “БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХ” ХӨТӨЛБӨРИЙН ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦЛОО.

Огноо: 2021/04/29

Үйл ажиллагаа: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр Азийн бүс нутагт хэрэгжүүлж байгаа “Бизнес ба хүний эрх: Хамгаалах, хүндэтгэх, зөрчигдсөн эрхийг сэргээх механизмаар дамжуулан эдийн засгийн өсөлтийг дэмжих нь” хөтөлбөрийн хүрээнд тус хөтөлбөрийг эхлүүлж байгаа юм.



- Нээлтэд Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр оролцож, НҮБ-аас гаргасан хариуцлагатай бизнесийг дэмжин хэрэгжүүлэх тухай суурь зарчим болох “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим”-ыг хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас авч буй алхмын талаар танилцуулав.
- Тэрээр Монгол Улс үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд нийгмийн бүх тал – иргэд, иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоог хангах явдлыг хүний хөгжлийг хангах сайн засаглалын суурь арга зүй болгон дэвшүүлснийг онцолж, “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим”-ыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөө гаргах үйл явц нь хүний эрхийг бүрэн хангасан үндэсний тогтолцоог бэхжүүлэх, олон талт түншлэлийг хөгжүүлэх, хүний эрхийг хүндэтгэсэн бизнесийн соёлыг нутагшуулахад бодит түлхэц болно гэж үзэж байгаагаа тэмдэглэв.
- Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр Монгол Улсын Засгийн газрын энэхүү хүчин чармайлтад тууштай дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж байгаад НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон Европын Холбоонд гүн талархал илэрхийлэв.
- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл 2015 онд Монгол Улс дахь хүний эрхийн хоёр дахь удаагийн тайланг хэлэлцэж, 150 зөвлөмж өгсний дотор НҮБ-аас 2011 онд гаргасан “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэх, энэ зорилгоор үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө батлах”-ыг уриалсан зөвлөмж багтсан. Монгол Улсын Засгийн газар 2016 онд 204 дүгээр тогтоолоороо, Хүний эрхийн зөвлөлийн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө баталж, үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах бодлогын шийдвэр гаргасан билээ. Гадаад харилцааны яам эл үйл явцыг манлайлан ажиллаж байна.

- Гурван жилийн хугацаанд хэрэгжих “Бизнес ба хүний эрх” төсөл нь үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлэх замаар хүний эрхийг хүндэтгэсэн хариуцлагатай бизнесийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах юм.

Үр дүн: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр Азийн бүс нутагт хэрэгжүүлж байгаа “Бизнес ба хүний эрх: Хамгаалах, хүндэтгэх, зөрчигдсөн эрхийг сэргээх механизмаар дамжуулан эдийн засгийн өсөлтийг дэмжих нь” хөтөлбөрийн хүрээнд тус хөтөлбөрийг эхлүүлж байгаатай холбоотойгоор бичил уурхай салбарт нийтлэг хүний эрхийн зөрчил, түүнийг хамгаалах, хүндэтгэх зарчим алдагддагтай холбоотойгоор, мөн бичил уурхайн салбараас өөр бизнес эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалт татах боломж байгаа талаар хамтын ажиллагааг бий болгох чухал байлаа. Иймд Бизнес ба хүний эрх сэдэвт хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаанд оролцов.

6. ӨМГӨӨЛЛИЙН ЮНАЙТЕД САММИТ ХХК-ТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА

Огноо: 2021/03/29

Үйл ажиллагаа: Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо гишүүддээ мэргэжлийн хууль зүйн үйлчилгээ үзүүлнэ.

- 2021.03.29-ний өдөр Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо нь Өмгөөллийн Юнайтед Саммит ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгууллаа. Энэхүү гэрээний зорилго нь Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоонд гишүүнчлэлтэй 13 аймгийн холбоод болон түүний гишүүн байгууллагууд, тэдгээрийн гишүүн бичил уурхай эрхлэгчдийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалж, бичил уурхай түүнийг тойрсон асуудлуудаар дагнасан мэргэжлийн, хууль зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж хамтран ажиллах юм.
- Өмгөөллийн Юнайтед Саммит ХХК нь 2015 оноос тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 10-аас дээш жилийн туршлагатай чадварлаг хуульчдаар багаа бүрдүүлсэн Монгол улсын хууль тогтоомж, стандартуудыг мөрдлөг болгон ажилладаг мэргэжлийн хуулийн фирмүүдийн нэг юм.



Үр дүн: Тус байгууллагатай хамтран ажилласнаар бичил уурхайн салбарын нийт байгууллагуудад хөндлөнгийн үнэлгээ хийж, салбарын үйл ажиллагааг бүхэлд нь судлан таньж мэдсэн ба тулгамдаж байгаа асуудлуудыг илрүүлснээр тус байгууллагаас салбарын хууль эрх зүйн зөвлөх үйлчилгээг авах, хэрэгцээ шаардлага байгааг тодорхойлсны дагуу хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа.

7. “ЭРДЭС БАЯЛАГ – ЭМЭГТЭЙЧҮҮД ҮНДЭСНИЙ III ЧУУЛГАН”-Д ОРОЛЦЛОО

Огноо: 2021/04/16

Үйл ажиллагаа: “Эрдэс баялаг – эмэгтэйчүүд үндэсний III чуулган” 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдөр цахимаар зохион байгуулагдлаа. Уг хуралд Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Бат-найрамдал оролцож “Хариуцлагатай ил тод уул уурхайг хөгжүүлэх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2020-2024” сэдвээр илтгэл тавилаа.



- Тэрээр илтгэлдээ: Эрдэс баялгийн салбар нь Монгол Улсын эдийн засагт хувь нэмрээ тасралтгүй оруулсаар ирсэн бөгөөд 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ-ий 22%, аж үйлдвэрийн салбар, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 71%, экспортын бүтээгдэхүүний 94%-ийг тус тус бүрдүүлсэн. Мөн төсвийн нийт орлогын 26% буюу 10.4 их наяд төгрөгийг уул уурхайн салбараас оруулсан орлого эзэлж байна.
- Салбарын алсын харааг зөв тодорхойлж, эрх зүйн шинэчлэлийг боловсронгуй болгож, боловсруулалтын түвшинг ахиулснаар хөгжлийн дараагийн үе шатанд шилжиж улс орны эдийн засагт үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэх боломжтой юм.
- Энэ хүрээнд 2020-2024 онд газрын тос боловсруулах үйлдвэр, нүүрс болон зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, хар төмөрлөгийн үйлдвэр зэрэг олон төсөл хөтөлбөр хэрэгжиж томоохон бүтээн байгуулалтын ажлууд өрнөх талаар мэдээлэл хүргэсэн.
- Илтгэлийнхээ төгсгөлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Бат-найрамдал эрдэс баялгийн салбарт үнэтэй хувь нэмэр оруулж буй 53.7 мянган ажиллагсдын 12 мянга орчим нь эмэгтэйчүүд байгааг онцлоод чуулганд оролцогч эмэгтэйчүүдэд хандан талархал илэрхийлж ажлын амжилт хүссэн юм.

Үр дүн: “Эрдэс баялаг – эмэгтэйчүүд үндэсний III чуулган”-д салбарын манлайлагч эмэгтэйчүүд өөрсдийн туршлагаа хуваалцаж, 300 гаруй төлөөлөгч эмэгтэйчүүд оролцож байгаагаас бичил уурхайн салбарын эмэгтэйчүүд идэвхтэй оролцон, салбарынхаа дуу хоолой болж байгаагаар онцлог байлаа.

БҮТЭЭГДЭХҮҮН: 2-ИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ:

Огноо	ҮА	Нийт			ТАХ			БУ			Бусад		
		Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм
02/28	1.1.1	5	3	2	0	0	0	5	3	2	0	0	0
06/30	1.1.2	5	1	4	0	0	0	5	1	4	0	0	0
03/10	1.2.1	15	10	5	8	6	2	2	0	2	5	4	1
01/00	1.2.2	24	14	10	0	0	0	24	14	10	0	0	
01/01	1.2.3	10	9	1	0	0	0	10	9	1	0	0	0
01/02	1.2.4	11	6	5	0	0	0	11	6	5	0	0	0

02/15	1.2.5	7	4	3	0	0	0	7	4	3	0	0	0
05/27	2.2.1	34	12	22	15	10	5	9	4	5	10	3	7
06/24	2.2.2	23	6	17	7	4	3	10	0	10	6	2	4
03/17	2.2.3	24	10	14	5	5	0	10	3	7	9	2	7
04/24	2.4.1	5	1	4	0	0	0	5	1	4	0	0	0
05/18	2.5.1	31	7	24	0	0	0	0	0	0	31	7	24
05/24	2.6.1	25	9	16	0	0	0	0	0	0	25	9	16
03/20	2.7.1	5	1	4	0	0	0	5	1	4	0	0	0
04/17	2.3.1	6	1	5	0	0	0	6	1	5	0	0	0
01/01	2.3.2	5	1	4	0	0	0	5	1	4	0	0	0
02/25	2.4.1	5	1	4	0	0	0	5	1	4	0	0	0
04/15	2.5.1	200	150	50	0	0	0	0	0	0	200	150	50
04/26	2.6.1	29	14	15	0	0	0	29	14	15	0	0	0
04/20	2.6.2	24	8	16	0	0	0	20	6	14	4	2	2
03/31	2.6.3	4	1	3	0	0	0	2	0	2	2	1	1
05/19	2.6.4	6	2	4	0	0	0	6	2	4	0	0	0
04/28	2.6.5	5	1	4	0	0	0	5	1	4	0	0	0
04/29	2.6.6	5	1	4	0	0	0	5	1	4	0	0	0
03/29	2.6.7	6	3	3	0	0	0	4	1	3	2	2	0
Нийт		519	276	243	35	25	10	190	74	116	294	182	112

БҮТЭЭГДЭХҮҮН 2-ИЙН ДҮГНЭЛТ ХЭСЭГ:

- Сургалт хөгжил зөвлөн туслах үйлчилгээ ба хяналт мониторинг, бүтээгдэхүүн 2-ийн хүрээнд 24 үйл ажиллагааг хэрэгжүүлсэн бөгөөд тус үйл ажиллагаануудыг хийж гүйцэтгэхэд оролцсон болон хэрэгжүүлсэн нийт 519 хүн давхардсан тоогоор хамрагдсан, эрэгтэй 276, эмэгтэй 243 хүн хамрагдсан байна. Үүнээс төрийн албан хаагчдын оролцоо 35, бичил уурхайчид болон гүйцэтгэх албанаас 190, бусад оролцог талууд ба ХАМО иргэд 294 хүн тус тус оролцоотой үйл ажиллагаа хэрэгжсэн байна.
- Дээрх үйл ажиллагаа тус бүрээс дэлгэрэнгүй танилцах боломжтой ба үйл ажиллагааны нэгдсэн дүгнэлт хэсгийг энэ хэсгээс харах ба тайлангийн хураангуйг тайлангийн төгсгөл хэсгээс харах боломжтойгоор бэлтгэсэн болно.

Удирдах зөвлөл болон гүйцэтгэх албаны хуралдаан түүнтэй холбоотой хийгдсэн ажил

1. **Удирдах зөвлөлийн гишүүдийн хуралдаан:** 2021 оны эхний улиралд удирдах зөвлөлийн хуралдаан зохион байгуулагдаж 2020 оны үйл ажиллагааны тайлантай холбоотой хэд хэдэн асуудлаар холбогдох шийдвэрүүдийг гаргав.
2. **Дотоод албаны 7 хоног бүрийн хуралдаан:** Дотоод уулзалт, хурлыг тогтмол 7 хоног бүрийн баасан гаригт хийж хэвшсэн ба ажлын уялдаа холбоог сайжруулахын зэрэгцээ, ажлын үр дүнг нэмэгдүүлэх, улмаар ажлыг тасралтгүй зохион байгуулах, цаг хугацаанд нь хэрэгжүүлэх чухал ач холбогдолтой байгааг дүгнэв.

Бичил уурхайн байгууллага, түүний гишүүдийг чадвахжуулах, чиглэлээр сургалт зохион байгуулах:

1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хүрээнд хийгдсэн тодорхой ажлуудыг тоймлон авч үзвэл журамд санал авах үйл ажиллагааг бичил уурхайн

аймгийн холбоодоос ирсэн саналд үндэслэн ажлын хэсэг, яам тамгын газруудад хүргүүлсэн ба ажлын хэсгийн гишүүнээр МБУНДХ-ноос 2 төлөөлөл орж ажиллаж байна.

2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд өөрчлөлт оруулахтай холбоотойгоор дээрх ажлын хэсэгт бичил уурхай бүхий аймгийн холбоодоос санал авах ажиллагааг зохион байгуулсан ба аймгийн холбоодын удирдлагуудын нэгдсэн уулзалтыг зохион байгуулж, нэгдсэн нэг ойлголтыг өгөх, саналаа албан бичгээр ирүүлэх тухай мэдээлэл өгөх онлайн уулзалтыг 2 удаа зохион байгуулсан.

Бичил уурхай бүхий аймгийн холбооны гишүүдийг чадвахжуулах зорилгоор хийгдсэн үйл ажиллагаанууд:

1. **Ховд** аймгийн бичил уурхайн байгууллагуудын нэгдсэн холбооны хүсэлтээр онлайн хэлбэрээр 2 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтанд 20 нөхөрлөлийн ахлагчид хамрагдсан ба бичил уурхайн хууль эрх зүйн өнөөгийн нөхцөл байдал, бүртгэлтэй нөхөрлөл байгуулах аргачлалын сургалтыг явууллаа.
2. **Сэлэнгэ** аймгийн холбооны гишүүдийн хүсэлтээр удирдах зөвлөлийн гишүүдээ шинэчлэн зохион байгуулах, үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилготойгоор МБУНДХ-нд хандсан тул, гишүүдийн оролцоотой ажлын хэсэг байгуулан удирдах зөвлөлийн бүтцийг шинэчлэн байгуулах зорилго чиглэл, хурлын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаа.
3. **Дундговь** аймгийн Хулд суманд үйл ажиллагаа явуулж буй “Тахилгат лусын булаг” ТББ-ын удирдах зөвлөлийн хуралдаанд оролцож, мэдээлэл өгч ажилласан.
4. **“Байгаль орчин, нийгмийн менежментийн систем” сургалт:** Планет голд төслөөс зохион байгуулсан тус сургалтанд МБУНДХ-ноос нөхөн сэргээлт хийхэд тулгамдаж буй асуудлууд сэдвээр сургалт, судалгаа хөгжлийн мэргэжилтэн Р.Түмэндэмбэрэл танилцуулга хийж оролцсон. Сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, бичил уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг уялдуулж ажиллах, хэрэгцээ шаардлагууд гарсан ба төлөвлөгөөнд тусгах асуудлууд, түүнийг шийдвэрлэх арга зам, хэрэгжүүлэх хөрөнгө мөнгийг хаанаас шийдвэрлэх вэ гэсэн асуудлуудаар оролцогчид бүлгийн хэлэлцүүлэг хийж танилцуулсан.
5. **Мөнгөн усны тухай минаматагийн конвенц ба бичил уурхай сэдэвт онлайн сургалт:** Алтны бичил уурхайн дахь мөнгөн усны хэрэглээг бууруулах, Минаматагийн конвенц, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд оролцогч талуудын мэдлэгийг нэмэгдүүлэх ач холбогдолтой сургалт болсон. Тус сургалтанд Сэлэнгэ аймагт зохион байгуулагдаж орон нутгийн удирдлагууд, бичил уурхайчид оролцсон.
6. **Бичил уурхайн аюулгүй байдлын дүрэм, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг баримтлах:** Бичил уурхайн салбарт ажиллаж байгаа гишүүдийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангаж ажиллуулахын тулд мэдлэг олгох сургалтыг ажил эхлэхийн өмнө бүх гишүүдийг заавал хамруулахаар бичил уурхайн журамд санал өгсөн ба тогтмол зохион байгуулахаар ажиллаж байна.

7. **Дэлхийн зөн ОУБ-ын хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн бизнесээ эхэл сургалт, Сэлэнгэ, Баянхонгор** аймгийн зорилтод бүлгийн бизнэсээ эхлүүлж байгаа оролцогчид хамрагдлаа. Өрхийн бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдлэг олгох тус сургалт онлайнаар зохион байгуулагдлаа, МБУНДХ-ны гэрээт сургагч багш нар хичээлийг хөтлөн явууллаа.
8. **Жендэр ба хүний эрхийн сургалт зохион байгуулах, хамтран хэрэгжүүлэх чиглэлээр планет голд төсөлтэй хамтран ажиллаж байна.** Бичил уурхайн салбарт ажиллаж байгаа гишүүдийн хүний эрх, жендэрийн ялгаварлан гадуурхалтад өртөлт нийтлэг байдаг тул эрхээ хамгаалах хэрэгцээ шаардлага байдагтай холбоотойгоор тус сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн хамтран ажиллаж байна.

Нэгдүгээр ангилалд багтсан аймгийн холбоодын үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагааны хүрээнд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа:

1. Нэгдүгээр ангилалд багтсан байгууллага нь Санхүүжилт авах, төсөл хэрэгжүүлэх бүрэн чадамжтай, бүх үйлчилгээнд хамрагдах боломжтой байгууллага гэсэн үзүүлэлтээр Өмнөговь, Говь-Алтай, Баянхонгор гэсэн 3 аймаг үнэлэгдсэн. Иймд тус аймгийн холбоодын үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна. Тогтвортой үйл ажиллагаагаа явуулж, гишүүдээ үзүүлэх үйлчилгээний хүртээмжээ нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой гэж үзэн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор тус бүр оёдлын цехийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн.
2. Мөн дээрх нэгдүгээр ангилалд багтсан аймгийн холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн бие даан үйл ажиллагаа хэрэгжүүлэх, хүний нөөцөө чадвахжуулах боломжийг нэмэгдүүлэхийн тулд бичил уурхайн шинэчлэгдсэн журмыг сурталчлан таниулах, сургалт зохион байгуулахад нь санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр боллоо.

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээний хэрэгжилтнд мониторинг хийх ажлыг үргэлжлүүлэх төлөвлөлт:

1. Бичил уурхайн салбарын үйл ажиллагааг бүхэлд нь сайжруулах, хариуцлагжуулхын тулд гэрээний хэрэгжилтийн хугацаанд мониторинг хийх, гэрээний талуудад үр дүнг танилцуулах, зөрчлийг арилгах, гэрээг дүгнэх хэрэгцээ шаардлагууд байгаа юм. Тус үйл ажиллагааг хэрэгжүүлсний дараагаар нийтэд танилцуулах ажлуудыг зохион байгуулж, цаашид жил бүр тогтмолжуулан зөрчлийг илрүүлэх, арилгах арга хэмжээг авч ажиллахаар төлөвлөж байна.

Хууль бус үйл ажиллагаанд оролцогч талуудад чиглэсэн арга хэмжээ:

1. **Хууль бус хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоохтой холбоотой хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа:** Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Азийн сангаас хэрэгжүүлж байгаа хууль бус үйл ажиллагаатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд манай байгууллагаас хамтран ажиллах, тухайлбал бичил уурхайн салбарын хууль бус олборлолтын үйл ажиллагаатай хамтран тэмцэх, мэдсээр байж хууль бус үйл

ажиллагаанд оролцогчдыг илрүүлэх, улмаар тэдний үйл ажиллагааг албажуулахад хамтран ажиллах байна.

Бичил уурхайн сайн туршлагыг түгээх, нэвтрүүлэх зорилгоор туршлага судлах аялал зохион байгуулах:

1. Энэхүү төлөвлөгөөт ажлыг хүрээнд тодорхой ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөсөн байгаа бөгөөд одоогоор дараах ажлууд хийгдсэн байна.
2. **Delve exchange project бичил уурхайчдын туршлага, мэдээлэл солилцох олон улсын төсөл нээлтийн үйл ажиллагаанд оролцоо:** Бичил уурхай бүхий улс орнуудын дунд Монгол улс тэргүүн сайн туршлагуудыг нэвтрүүлсэн, сайн жишээ болохуйц үйл ажиллагаа явуулдагараа манай улсын бичил уурхайн салбараас хуваалцах зүйл ихээхэн байгаа тухай тус төслийн үеэр онцолсон юм. Мөн манай салбарт тулгамддаг хэдэн хэдэн асуудлаар асуулт асууж, цаашид үйл ажиллагаандаа бусад улс орны сайн туршлагыг нэвтрүүлж, нутагшуулахад анхаарахаа илэрхийлсэн юм.

Хамтын ажиллагааны хүрээнд хийж хэрэгжүүлсэн бусад үйл ажиллагаа:

3. **Канадын Бритиш колумын их сургууль, Герман Монголын хамтарсан ашигт малтмалын технологийн их сургуулиас, Бичил уурхай эрхлэгчдийн нийгэм эдийн засгийн байдалд ковид-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийн судалгааны танилцуулга:** Тус судалгааны үр дүнг танилцуулах цахим уулзалтуудад МБУНДХ-ны 13 аймгийн холбоодын гишүүд оролцов. Судалгааны багийн гишүүдийн танилцуулж буй судалгааны үр дүнд бичил уурхайн салбарт Ковид-19 цар тахал хэрхэн нөлөөлж буйг гаргаж ирснээр тэдний өрхийн болоод, улс орны эдийн засагт үзүүлж буй хувь нэмэр, амьдралын түвшин буурсан үзүүлэлттэй байгааг эрх барих, шийдвэр гаргах, холбогдох яам тамгын газарт танилцуулан цаашид анхаарах хэрэгтэй байгааг онцлов.
4. **Дэлхийн зөн Монгол, Олон улсын байгууллагаас зарласан сургалт зохион байгуулах тэтгэлэгт саналаа хүргүүлж, тэтгэлэгт хамрагдсанаар, сургалт зохион байгуулах гэрээ байгуулав:** Тус тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан “Бизнесээ эхэл” сургалтыг зохион байгуулах зорилготой хамтран ажиллах 3 жилийн гэрээ байгуулан. Гэрээний дагуу 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, гэрээг амжилттай дүгнэж байна.
5. **Ховд аймгийн холбооны хүсэлтийг хүлээн авч, хамтран ажиллах гэрээ байгууллаа:** Ховд аймагт бичил уурхайн аймгийн холбоо байгуулагдан үйл ажиллагаа явуулж байсан хэдий ч гишүүдийн оролцоо, итгэлцэл хамтын ажиллагаа суларснаас гишүүд аймгийн холбоогоо шинэчлэн байгуулж, удирдлагын бүтцийг өөрчлөн, сонгож үйл ажиллагааг нь эрчимжүүлэн ажилласантай холбоотойгоор Алтан уулын эзэд ТББ-ыг байгуулан, хамтын ажиллагаагаа эхлүүлсэн юм.
6. **Нээлттэй нийгэм форум “Төрийн болон орон нутгийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авалтын ил тод байдал” судалгааны тайлангийн цахим**

хэлэлцүүлэг: Нээлттэй нийгэм форум байгууллагатай хамтран ажиллаж байгаатай холбогдуулан тус байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцоотой, хамтын ажиллагаатай ажиллаж байгаа бөгөөд тус судалгааны тайлангийн цахим хэлэлцүүлэгт оролцож, судалгааны үр дүнтэй танилцав.

7. **Монгол улс дахь “Бизнес ба хүний эрх” хөтөлбөрийн хэлэлцүүлэг:** НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр Азийн бүс нутагт хэрэгжүүлж байгаа “Бизнес ба хүний эрх: Хамгаалах, хүндэтгэх, зөрчигдсөн эрхийг сэргээх механизмаар дамжуулан эдийн засгийн өсөлтийг дэмжих нь” хөтөлбөрийн хүрээнд тус хөтөлбөрийг эхлүүлж байгаатай холбоотойгоор бичил уурхай салбарт нийтлэг хүний эрхийн зөрчил, түүнийг хамгаалах, хүндэтгэх зарчим алдагддагтай холбоотойгоор, мөн бичил уурхайн салбараас өөр бизнес эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалт татах боломж байгаа талаар хамтын ажиллагааг бий болгох чухал байлаа. Иймд Бизнес ба хүний эрх сэдэвт хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаанд оролцов.
8. **Өмгөөллийн юнайтед саммит ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан:** Тус байгууллагатай хамтран ажилласнаар бичил уурхайн салбарын нийт байгууллагуудад хөндлөнгийн үнэлгээ хийж, салбарын үйл ажиллагааг бүхэлд нь судлан таньж мэдсэн тус байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг байгуулав. Бичил уурхайн салбарт тулгамдаж байгаа асуудлуудаар зөвлөх үйлчилгээ үзүүлэн хамтран ажиллаж байна.
9. **Эрдэс баялаг эмэгтэйчүүдийн үндэсний III дугаар чуулганд оролцсон тухай:** Тус чуулган жил бүр уламжлан болон зохион байгуулагддаг бөгөөд уул уурхайн салбарт эмэгтэйчүүдийн оролцоо, оруулж буй хувь нэмэр, эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх гарцыг чуулганаас гарсан зөвлөмжид тусган Засгийн газарт өргөн барьдаг ба Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, тэр дундаа эмэгтэйчүүдэд чиглэсэн үйл ажиллагааг онцлон тэмдэглэдэг. Мөн бичил уурхайн салбарын дуу хоолой болж буй салбарын эмэгтэйчүүд тус чуулганы үеэр саналаа хэлж оролцосныг дүгэнлээ.

ҮЙЛ АЖИЛЛАГАА: 3.1: БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

ҮА: 3.1.1: ОРОН НУТГИЙН БИЧИЛ УУРХАЙ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨН

Огноо: 2021/02/27

Үйл ажиллагаа: Баянхонгор аймгийн хариуцлагатай бичил уурхайн байгууллагуудын нэгдсэн холбооны тэргүүн М.Цэцгээ, гүйцэтгэх захирал Ж.Саруул болон түүний гишүүн байгууллагуудын тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүд, нөхөрлөлийн ахлагч нар Баянхонгор аймгийн хөгжлийн зөвлөгөөнд төлөөлөгчөөр оролцон саналаа илэрхийлжээ.



9. Тус хөгжлийн зөвлөгөөний үеэр Баянхонгор аймгийн хариуцлагатай бичил уурхайн байгууллагуудын нэгдсэн холбооны тэргүүн М.Цэцгээ хэлэлцэж буй 7 төсөлд бичил уурхайчдыг хамруулж, ажлын байртай болгох талаар санал оруулсан байна.

Үр дүн: Баянхонгор аймгийн хөгжлийн зөвлөгөөнд бичил уурхайн салбарыг онцлон авч үзсэн ба бичил уурхайн аймгийн холбоогоор дамжуулан, гишүүдийг оролцуулсан нь оролцоог хангасан зөвлөгөөн бий болсон гэж үзсэн. Бичил уурхайн салбарт ажиллагсдыг өөр ажлын байранд шилжүүлэх үндсэн зорилготой уялдуулан орон нутагт хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт хамруулах талаар саналаа илэрхийлсэн. Тус зөвлөгөөнд нийт 120, үүнээс төрийн албан хаагчид-23, бичил уурхайчид-19, үлдсэн нь уул уурхайн компани, бусад салбарын төлөөлөл байсан. Бичил уурхайд хамааралтай гэж үзсэн 42 үүнээс эрэгтэй-26, эмэгтэй-16 байсан.

2. ХОВД АЙМГИЙН АЛТАН УУЛЫН ЭЗДИЙН ХОЛБОО

Огноо: 2021/02/21

Үйл ажиллагаа: Ховд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Алтан уулын эздийн

холбоон нь бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа байгаа бичил уурхайн нөхөрлөлүүдийн нэгдсэн байгууллага бөгөөд бичил уурхай бүхий сумуудад очин тэдний өмнө тулгамдаж буй асуудлуудын талаар зөвлөгөө өгч ажилласан байна.



- Тэрээр бичил уурхайн салбарын эрх зүйн орчинтой холбоотой үйл ажиллагаа зогсонги байгаа хэдий ч Булган суманд үйл ажиллагаа явуулж буй нөхөрлөлүүд, орон нутгийн удирдлагуудын хүсэлтээр ажиллаж, тэдний асуудлыг шийдвэрлэхийн тулд нэгдсэн хуралдаан зохион байгуулагдаж, хурлын үеэр МБУНДХ-ноос шууд зөвлөгөө өгч ажилласан юм.
- Тус уулзалтаар сумын засаг даргатай, аймгийн холбоо хамтран ажиллах гэрээ байгуулсан ба 30 гаруй нөхөрлөлийн гишүүд аймгийн холбоонд гишүүнээр элссэн ба гишүүний үнэмлэхээ гардаж авсан байна.

Үр дүн: Ховд аймгийн хэмжээнд аймгийн холбоо шинэчлэн байгуулагдсан, түүний гишүүдийн өмнө тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд зөвлөх үйлчилгээ үзүүлэн, МБУНДХ-той нягт хамтран ажиллаж байна. Гишүүдийн ажлын байрны тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажилласан үр дүнгүүдийг дурдаж болно. Тус хуралд нийт 56 үүнээс эрэгтэй-51, эмэгтэй-5, үүнээс орон нутгийн удирдлагуудаас 3 оролцсон.

БҮТЭЭГДЭХҮҮН-3: БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТООН МЭДЭЭЛЭЛ:

Огно о	ҮА	НИЙТ			ТАХ			БУ			БУСАД		
		Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм
02/27	3.1	42	26	16	23	20	3	19	6	13	0	0	0
02/21	3.2	56	51	5	3	3	0	53	48	5	0	0	0
	Нийт	98	77	21	26	23	3	72	54	18	0	0	0

БҮТЭЭГДЭХҮҮН 3-ИЙН ДҮГНЭЛТ ХЭСЭГ:

1. Бүтээгдэхүүн 3-ийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн 2 үйл ажиллагааг оруулж өгсөн ба орон нутгийн бичил уурхайн байгууллагуудын оролцоотой зохион байгуулагдсан үйл ажиллагааг онцлон авч үзсэн ба энэ үйл ажиллагааг зохион байгуулахад нийт хамааралтай 98 хүн хамрагдаж, эрэгтэй-77, эмэгтэй-21 байна. Үүнээс төрийн албан хаагчдын оролцоо 26, бичил уурхайчид ба гүйцэтгэх албаны 72, бусад буюу ХАМО иргэд оролцоогүйгээр дээрх 2 үйл ажиллагаа гишүүд болон төрийн албан хаагчдын оролцоотойгоор зохион байгуулагдсан байна.

Бусад үйл ажиллагаа, буюу орон нутгийн бичил уурхайн гишүүн байгууллагуудын оролцоотой зохион байгуулагдсан дээрх үйл ажиллагаанд Баянхонгор аймагт зохион байгуулагдсан Баянхонгор аймгийн хөгжлийн зөвлөгөөний тухай товч оруулсан, тухайлбал Баянхонгор аймаг бүс нутгийнхаа хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажлын хүрээнд бичил уурхайн салбарын үйл ажиллагааг тусгасан тодорхой ажлуудыг танилцуулсан ба бичил уурхайчдыг тус зөвлөгөөнд урьж оролцуулсан онцлог үйл ажиллагаа болсон байна. Тус зөвлөгөөний үеэр аймгийн холбооны тэргүүн М.Цэцгээ саналаа илэрхийлсэн ба бичил уурхайчдын амьдралын чанар, өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд анхаарч үзээсэй гэсэн хүсэлтийг тус зөвлөгөөний үеэр илэрхийлснийг аймгийн удирдлагууд дүгнэлт хэсэгтээ оруулан танилцуулсан байна.

2. Бусад үйл ажиллагаа буюу орон нутгийн бичил уурхайн үйл ажиллагааны хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлаар Ховд аймгийн холбоо буюу Алтан уулын эздийн холбооны хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааг онцлон авч үзсэн юм. Тэрээр Булган сумын засаг дарга бичил уурхайн салбарын үйл ажиллагаанд оролцож байгаа иргэдийн үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах санамж бичиг байгуулан, нөхөрлөлүүдтэй хамтран ажиллахаа илэрхийлсэн байна.

Аймгийн холбоо гишүүнчлэлийнхээ хүрээг тэлсэн ба бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогч талуудын үйл ажиллагааг албажуулахад анхаарч ажилласан үйл ажиллагаа болсон байна.

БҮТЭЭГДЭХҮҮН-4: НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

ҮЙЛ АЖИЛЛАГАА: 4.1: ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН САЛБАР, АЖИЛТНУУДАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ҮА: 4.1.1: Сэтгүүлчдэд чиглэсэн сургалт, уулзалт зохион байгуулах, тодорхой хэвлэл мэдээллийн байгууллагуудтай тогтмол хамтран ажиллах гэрээ байгуулан хамтран ажиллах замаар хариуцлагатай уул уурхайн сэтгүүлчдийн клубийг үүсгэн байгуулж сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын тодорхой хэсэгт бичил уурхайн салбарыг хүлээн зөвшөөрүүлэх, бичил уурхайн салбарын талаар эерэг мэдээ мэдээллүүдийг тогтмол олон нийтэд хүргэх

1. БИЧИЛ УУРХАЙН САЙН ТУРШЛАГЫГ БИЙ БОЛГОЖ БУЙ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДЫН ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ОРОН НУТГИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА.

Огноо: 2021/01/01-06/30

Үйл ажиллагаа: Бичил уурхайн салбарын сайн туршлагыг олж илрүүлэх, түүгээрээ дамжуулан бичил уурхайн салбарын хуулийн дагуух үйл ажиллагааг дэмжих, бусад орон нутагт нутагшуулах зорилгоор туршлага солилцох аяллыг зохион байгуулах зорилготойгоор ийнхүү тус ажлыг төлөвлөсөн хэдий ч ковид цар тахал, бичил уурхайн журмын зогсонги байдлаас шалтгаалан тус үйл ажиллагаа хойшлогдож байна.

- Гэсэн хэдий ч бичил уурхай үйл ажиллагаанд хориг тавьсан 355-р тогтоолоос өмнө гэрээгээр ажиллаж байсан хэд хэдэн үйл ажиллагаанууд хэвийн явагдаж, тэдний ажлын нөхцөл байдал сайжирч байгаа хэд хэдэн орон нутаг байгааг онцлон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээх ажил хэвийн явагдаж байна. Мөн бичил уурхайн салбарын үйл ажиллагаа зогсонги байгаа орон нутгуудад эерэг сайн үйл ажиллагаа үргэлжилсээр байгааг энэ удаад онцлон хүргэж байна. Үүнд:
 1. Сэлэнгэ аймгийн Мандал сум, Хэрх тосгоны бичил уурхайчид өөрсдийнхөө санаачилгаар ахуйн хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулсныг нь орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага онцлон мэдээлсэн байна.

2. Мөн Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгонд үйл ажиллагаа явуулж байгаа Баатар Вангийн Хишиг Холбоо ТББ-ын гишүүд өөрсдийнхөө санаачилгаар орон нутгийнхаа ахуйн хог хаягдлыг цэвэрлэх компанит ажлыг өрнүүлснийг орон нутгийн фэйсбүүк бүлгэмд маш олон талархал хүлээсэн пост болсныг онцолсон юм. Мөн тус байгууллага ковид-19 цар тахлын нөхцөл байдалд тулгуурлан орон нутгийнхаа ЭМБайгууллагад болон өндөр настнуудад хандив өгсөн байна.



3. **Баянхонгор** аймгийн ХАМОДХ ТББ нь өөрсдийн санаачилгаар ковид цар тахлын хүнд хэцүү нөхцөл байдалд эрүүл мэндийн байгууллагад тусламж үзүүлж, нийгэмд эерэг нөлөөлөл бий болгосон сайн жишээг мөн дурьдаж болно. Аймгийн холбооны гишүүн ХАМОДХ ТББ-аас аймгийн Онцгой комисст 7500 ширхэг маск, Баян-овоо сумын Онцгой комисст 500 ширхэг маск, Эрдэнэ мандал багт 2500 ширхэг маск тус тус хандивласан ба хүндрэлтэй байгаа малчдад туслах аяныг өрнүүлснийг орон нутгийн хэвлэл мэдээллийн алба, ТВ-үүд онцолсон байна.

4. **Ховд** аймгийн холбооны гишүүд хамтран аймгийн Онцгой байдлын комисст 5000 ширхэг амны хаалт хандивласан ба Оргил Алтай нөхөрлөл зорилтод өрхийг сонгон 5 өрх бүрт 1 тонн нүүрс, өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний тусламж үзүүлснийг орон нутгийн Ховд.мн мэдээллийн хөтөлбөр онцолсон байна.



5. **Дорноговь** аймгийн холбооны Айраг сумын бичил уурхайн нөхөрлөлүүд сумын эрүүл мэндийн төв, цагдаагийн албанд нийт 3000 ширхэг маск, 2 ширхэг халуун хэмжигчийг хандивласан бол, нийт 65 сая төгрөгийн төсөвтэй хөл бөмбөгийн талбай байгуулах ажлын явц 85 хувийн гүйцэтгэлтэй явж байгааг орон нутгийн хэвлэл мэдээлэл онцолсон байна.
6. **Өвөрхангай** аймгийн холбооны Хайрхан дулаан суманд үйл ажиллагаа явуулж буй Хиймортын хишиг нөхөрлөл нь нийгмийн хариуцлагын хүрээнд 1-р багт 100,000, цэцэрлэгт 300,000, 5-р багт мал угаалгын помп, шаланк 1,500,000, сумын цагдаагийн хэсэгт 500,000, аймгийн цагдаагийн ойд 1,000,000, багийн хуралд 200,000, 6-р багт 100,000, суманд 5,000,000 барьцааны 4,000,000 хандив, улсын онцгой комисст 500,000 төгрөг нийт 12,750,000 төгрөгийг хандив дэмжлэг өгч хөрөнгө оруулалт хийснийг сумын засаг дарга А.Батсайхан тодорхойлсон байна.

7. **Өмнөговь** аймгийн холбооны гишүүн, Гурвантэс суманд үйл ажиллагаа явуулж буй Тэсийн өглөө нөхөрлөл тус сумын Гоёот багийн нутагт байрлах “Загт боом” нэртэй 300 га талбайд 200,000 ширхэг Заг тариалсан байна. Тус нөхөрлөлийн үйл ажиллагаанд аймаг, сум, МБУНДХ-ноос дэмжлэг үзүүлэн ажилласны үр дүнд нөхөрлөлийн гишүүдийн санаачилсан заг тарих ажил амжилттай хэрэгжсэнийг орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага онцолсон байна.



Үр дүн: 2021 оны 6 дугаар сарын 30-ны хагас жилийн байдлаар орон нутагт хийж хэрэгжүүлсэн хандив тусламж, нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудтай хамтран олон нийтийн сувгаар түгээж, сайн үйлсийг алдаршуулан, бичил уурхай сайн туршлагын нэвтрүүлэн уриалга болгон бичил уурхайн салбарыг эерэгээр ойлгуулах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА: 4.2: ОЛОН НИЙТ, ШИЙДВЭР ГАРГАГЧДАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ҮА: 4.2.1: ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ, СОНИН, ТЕЛЕВИЗ, НИЙГМИЙН СҮЛЖЭЭНИЙ СУВГУУДЫН КОНТЕНТҮҮДИЙГ БЭЛТГЭЖ, ЦАЦАХ, НӨЛӨӨЛЛИЙН АЯН ЗОХИОН БАЙГУУЛАХ, УРЛАГИЙН КОНТЕНТ БЭЛТГЭЖ ЦАЦАХ, ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛЖ МЭДЭЭЛЭХ ЗАМААР ОЛОН НИЙТ, ОРОН НУТГИЙН УДИРДЛАГУУД, ШИЙДВЭР ГАРГАГЧДАД БИЧИЛ УУРХАЙН САЛБАРЫГ ТАНИУЛАХ, ЯЛГААТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЙЛГУУЛАХ. САЛБАРЫН ЭЕРЭГ ТУРШЛАГУУДЫГ БАГТААСАН ТАНИЛЦУУЛГА ГАРГАХ.

1. ШИЙДВЭР ГАРГАГЧДАД ЧИГЛЭСЭН НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Огноо: 2021/01/01-6/30

Үйл ажиллагаа: Олон нийт шийдвэр гаргагчдад чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын шинэчилсэн төсөлд оруулсан санал бүрэн тусгагдсан байх, шийдвэр гаргагчид дэмжиж ажилладаг байгаа гэсэн зорилгоор яам тамгын газрууд, ажлын хэсгийн гишүүд, улсын их хурлын гишүүдэд бичил уурхайн салбарын түүхээс эхлэн өнөөг хүртэлх бүхий л түвшинд салбарын мэдээллийг агуулсан албан бичгийг бэлтгэн хүргүүлэхийн зэрэгцээ нүүр тулсан ярилцлага, уулзалтуудыг удаа дараа зохион байгуулсан.

- Түүнчлэн бичил уурхайгаар ашигт малтмал олборлох 151-р тогтоолоор батлагдсан журмыг хүчингүй болгох санал гарсантай холбогдуулан яамдуутай уулзан, бичил уурхайн салбарын нөхцөл байдлыг олон талаас нь ойлгуулах ажлыг удаа дараа зохион байгуулсан бөгөөд хэвлэл мэдээллийн салбараар дамжуулан хүргүүлсэн мөн сонгуулийн жилтэй холбогдуулан үндэсний хэмжээнд уулзалтуудыг зохион байгуулсан. Мөн бичил уурхайн журамд санал авах ажиллагаатай холбоотойгоор нөлөөллийн ажлуудыг зохион байгуулж байна. Бичил уурхайн журмын саналыг бичил уурхай бүхий аймаг, орон нутгуудаас санал авах ажиллагааг зохион байгуулсан, мөн яамдуудаас санал авах ажиллагаа ч мөн хийгдсэн тул талуудыг мэдээллээр хангах ажлыг нөлөөллийн ажлаараа дамжуулан хийж хэрэгжүүлж байна.

Үр дүн: 2021 оны 6 дугаар сарын 30-ны хагас жилийн байдлаар бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг шинэчлэх зорилготой байгуулагдсан ажлын хэсэгт орж ажилласан төлөөлөгчдөөрөө дамжуулан саналаа оруулах, аймаг, яамдуудаас санал авах түвшинд бичил уурхайн салбарын үйл ажиллагааг нөлөөллийн албан бичиг, уулзалтуудаар хүргэж ажиллаа.

БҮТЭЭГДЭХҮҮН: 4-ИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ:

Огноо	ҮА	НИЙТ			ТАХ			БУ			БУСАД		
		Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм
06/30	4.1.1	250	140	110	45	33	12	205	107	98	0	0	0
06/30	4.2.1	120	86	34	43	35	8	77	51	35	0	0	0
#	Нийт	370	226	144	88	68	20	282	158	133	0	0	0

БҮТЭЭГДЭХҮҮН 4-ИЙН ДҮГНЭЛТ ХЭСЭГ:

- Бүтээгдэхүүн 4-ийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн нөлөөлөл, хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны сэдвээр 2 тодорхой ажлыг нэгтгэн дүгнэж харуулж байна. Ийнхүү хийж хэрэгжүүлсэн 2 үйл ажиллагаа нь 6 аймагт хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд нийт 370 орчим хүн хамрагдаж эрэгтэй-226, эмэгтэй-144 байна. Үүнээс төрийн албан хаагчид 88, бичил уурхайчид буюу гүйцэтгэх албаны 282, бусад болон ХАМО иргэдийн оролцоо байхгүйгээр тус ажлууд хэрэгжсэн байна.

2021 оны 6 дугаар сарын 30-ны хагас жилийн байдлаар орон нутагт хийж хэрэгжүүлсэн хандив тусламж, нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудтай хамтран олон нийтийн сувгаар түгээж, сайн үйлсийг алдаршуулан, бичил уурхай сайн туршлагын нэвтрүүлэн уриалга болгон бичил уурхайн салбарыг эерэгээр ойлгуулах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн байна

- Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг шинэчлэх зорилготой байгуулагдсан ажлын хэсэгт орж ажилласан төлөөлөгчдөөрөө дамжуулан саналаа оруулах, аймаг, яамдуудаас санал авах түвшинд бичил уурхайн салбарын үйл ажиллагааг нөлөөллийн албан бичиг, уулзалтуудаар хүргэж ажиллаа.

БҮТЭЭГДЭХҮҮН-5: БАЙГУУЛЛАГЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ

ҮЙЛ АЖИЛЛАГАА: 5.1: БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ, ХӨГЖҮҮЛЭХ.

ҮА: 5.1.1: ASMНUB.MN ВЕБ САЙТЫН ЭРХИЙГ ШИЛЖҮҮЛЭН АВЧ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХӨТЛӨХИЙН ЗЭРЭГЦЭЭ ХӨГЖҮҮЛЭЛТ ХИЙЖ, САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР ОЛЖ БОЛОХ ПЛАТФОРМТОЙ ХОЛБУУЛАХ. ХӨГЖҮҮЛЭЛТ ХИЙХ.

1. ВЕБ САЙТЫН ЭРХИЙГ ШИЛЖҮҮЛЭН АВСАН ТУХАЙ

Огноо: 2021/03/01-06-19

Үйл ажиллагаа: 21-р зууны цахим эрин зуунд бичил уурхайн салбар мэдээллийн технологийг өөрсдийн үйл ажиллагаанд ашиглан албан ёсны веб сайтыг хөгжүүлэн авч явснаар Монголын бичил уурхайн салбарт ажиллагсад болон дэлхийн хэмжээнд бичил уурхайн салбарт ажиллаж байгаа сая сая бичил уурхайчидтай мэдээлэл, туршлагаа солилцохын зэрэгцээ урт хугацаандаа сайтын хандалтыг нэмэгдүүлснээр санхүүгийн тодорхой эх үүсвэрийг бий болгож чадах тул бид Швейцарын хөгжлийн агентлагийн тогтвортой бичил уурхайн төслийг хэрэгжүүлсэн ажлын үр дүнд хийгдсэн **ASMНUB.MN** веб сайтыг өөрсдийн өмчлөлд шилжүүлэн авч цаашид хөгжүүлэлт хийн ажиллахаар 2021 оны төлөвлөгөөнд оруулан ажлыг тус оны нэгдүгээр улиралд эхлүүлсэн.

- Тус ажлын хүрээнд Швейцарын хөгжлийн агентлаг болон Ашигт малтмалын газар, Датаком ХХК –уудтай удаа дараагийн уулзалтыг зохион байгуулж уулзалтын дагуу албан тоотоор 3-р сараас эхлэн харилцсаны үр дүнд Швейцарын хөгжлийн агентлагийн газраас дээрх веб сайттай хамаарах 12 сая төгрөг-ний өр төлбөрийг барагдуулах нөхцөлтэйгөөр зөвшөөрөл бүхий албан тоотыг хийж өгсөн билээ. Иймд бид тусдаа сервертэй өөрийн өртөг нь 50 гаран сая төгрөгийн үнэ бүхий цогц сайтын эзэмшигч болсон.
- Дээрх ажлын хүрээнд сайтад хамаарах 12 сая төгрөг ний өр төлбөрийг 8 сая болгон хөнгөлүүлэх ажлыг Датакомтой ХХК –тай хийсэн удаа дараагийн хэлэлцээрийн үд дүнд амжилттай хийж чадсан.

Үр дүн: Тусдаа сервер бүхий 50 орчим саяын өртөг бүхий веб сайтыг 6 сая төгрөгөөр байгууллагын эзэмшилд авсан. Цаашид хөгжүүлэлт хийн Google add зэрэг платформтой холбож орлогын эх үүсвэрийг бий болгох чиглэлд ажиллана. Байгууллагын пассив хөрөнгийн үнэлгээ нэмэгдэнэ. Онлайн сургалтын платформ ажиллуулах зардал багасна. Нөлөөллийн ажлыг сайтаар дамжуулан хийж задралаа багасгаж, илүү олон хүнд хүрч ажиллана.

ҮЙЛ АЖИЛЛАГАА: 5.2: ХАБ-ЫН АЛБАН ЁСНЫ СУРГАЛТЫН ЭРХ АВАХ, ТӨЛБӨРТЭЙ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРҮҮД ГАРГАХ

ҮА: 5.2.1: АЛБАН ЁСНЫ СУРГАЛТЫН ЭРХ АВНА. ЭНЭ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭШСЭН ХУУЛИЙН ЗӨВЛӨХТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАН АЖИЛЛАНА. МӨН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОЛОН ХАБ-ЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР ГАРГАХ

1. БИЧИЛ УУРХАЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛЫН АЛБАН ЁСНЫ СУРГАЛТ ЯВУУЛАХ ТУХАЙ

Огноо: 2021/01/03-06.30

Үйл ажиллагаа: Тусгай зөвшөөрлийг авах ажлыг 1-р сараас эхлүүлэн тодорхой үе шаттай хэрэгжүүлэн одоогийн байдлаар Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын яаманд хүлээлгэн өгсөн.

- Уг ажлын хүрээнд хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 12-дугаар сарын 19 ний А/370 тоот тушаалын 2-р хавсралтаар батлагдсан ХАБЭА-ын сургалтын хөтөлбөрийн дагуу 892 хуудас бүхий сургалтын иж бүрэн материалыг бэлтгэн гаргасан. Яамны тавьсан нөхцөлийн дагуу сургалтын кабинетийг гүйцэтгэх албаны хамт тохижуулсан. Мөн ажлын хүрээнд хуулийн зөвлөхтэй зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байгаа.

Сургалтын материал бэлтгэсэн сэдвүүд

Д/д	Сэдэв	Цаг
1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ерөнхий ойлголт	1
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд мөрдөх хууль, дүрэм, журам, техникийн зохицуулалт, стандарт	2
3	Байгууллагын ХАБЭА-н удирдлага, зохион байгуулалт, дүрэм, журам	1
4	ХАБЭА-н арга хэмжээний төлөвлөгөө, төсөв, санхүүжилт	1
5	Ажлын байрны эрсдэлийг илрүүлэх, үнэлэх арга, урьдчилан сэргийлэлтийн зарчим	1
6	Мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлийг илрүүлэх, үнэлэх арга, урьдчилан сэргийлэлтийн зарчим	1
7	Ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалтын зохион байгуулалтын зарчим	1
	Бүгд	8

НИЙТ АЖИЛТНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Д/д	Сэдэв	цаг
-----	-------	-----

1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ерөнхий ойлголт	1
2	Хөдөлмөрийн тухай хууль	1
3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль	1
4	Үйлдвэрлэлийн осолд хүргэдэг аюултай хүчин зүйлс, урьдчилан сэргийлэлт	2
5	Ажлын байран дахь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлсийн төрлүүд, мэргэжлээс шалтгаалсан өвчин /МШӨ/	1
6	Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн төрлүүд, зохистой хэрэглээ	1
7	Ажлын байран дахь осол, өвчлөл үүсгэж болзошгүй хүчин зүйлсийг таньж илрүүлэх, мэдээлэх, урьдчилан сэргийлэхэд ажилтны үүрэг, оролцоо	1
8	Ажил эхлүүлэхээс өмнө эрсдэлийн үнэлгээ хийх арга, практик дадлага	1
9	Онцгой байдалд хэрэгжүүлэх арга хэмжээ, гамшгийн бэлэн байдал	1
10	Осолд өртөгсдөд үзүүлэх анхны тусламж	1
11	Ажилтны зан үйлтэй холбоотой өвчлөл, түүний урьдчилан сэргийлэлт	1
	Нийт	12

ХАБЭА-Н АСУУДАЛ ХАРИУЦСАН АЖИЛТНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Д/д	Сэдэв	цаг
1.	ХАБЭА-н удиртгал хичээл	2
2.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж	8
3.	Хөдөлмөрийн аюулгүй байдал	18
4.	Хөдөлмөрийн эрүүл ахуй	18
5.	ХАБЭА-н сургалт, зааварчилга	10
6.	Эрсдэлийн менежмент	12
7.	Хувийн хамгаалах хэрэгслийн хэрэглээ, тавигдах шаардлага	10
8.	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, мэдээлэх, дүн шинжилгээ хийх	10
9.	Аюулыг илрүүлэх, мэдээлэх харилцаа	10
10.	ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛТГЭЛ, БЭЛЭН БАЙДАЛ, ГАЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА	6
11.	Хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	10

12.	ХАБЭА-н менежментийн тогтолцоо	10
	Нийт	124

ХАБЭА-Н ТУСГАЙ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

№	Чиглэл	цаг
1	Тоног төхөөрөмжтэй харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа	9
2	Температурын эрс тэс нөхцөлд ажиллах аюулгүй ажиллагаа	12
3	Далд уурхайн аюулгүй ажиллагаа	12
4	Ил уурхайн үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа	12
5	Баяжуулах үйлдвэрийн аюулгүй ажиллагаа	12
6	Цахилгааны аюулгүй ажиллагаа	14
7	Галын аюулгүй байдал	10
8	Барилгын аюулгүй ажиллагаа	20
9	Бичил бизнес эрхлэгчдэд зориулсан аюулгүй ажиллагаа	6
10	Мал аж ахуйн аюулгүй ажиллагаа	6
11	Тээврийн аюулгүй ажиллагаа	6
12	Анхны тусламжийн сургалт	30

Үр дүн: ХАБ-ын Сургалтын 174 цагийн иж бүрэн хөтөлбөртэй болсон. Яамны шаардлагад нийцүүлэн сургалт явуулах анги танхимыг бэлдсэн. Сургалт явуулах ажлын бизнес төлөвлөгөө, ТЭЗҮ -г бичиж бэлэн болгосон. 2021 оны 7-р сард тусгай зөвшөөрлийг авах.

ҮЙЛ АЖИЛЛАГАА: 5.3: ОНЛАЙН СУРГАЛТЫН ПЛАТФОРМ БИЙ БОЛГОХ

ҮА: 5.3.1: Байгууллагын цахим сайтыг сургалтын платформ чиглэлээр хөгжүүлэх.

1. ЦАХИМ ПЛАТФОРМТОЙ БОЛСОН ТУХАЙ

Огноо: 2021/04/16-06.19

Үйл ажиллагаа: 2021 оны 4-р сараас эхлэн байгууллагын сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулах боломжийг бүрдүүлэх цахим мэдлэгийн баазыг бий болгох ажлыг API Solution ХХК тай гэрээлэн зайны сургалтын системийг хөгжүүлэн ажиллаж бэлэн болгоод байгаа.

- 2021оны 6,7 р сард зайн сургалтын системийг байгууллагын сайтад байршуулах, суулгах, туршилтын ажлыг хийж гүйцэтгэх бөгөөд 7-р саас албан ёсоор ажлыг хүлээн авч сургалтанд ашиглаж эхэлнэ.

Үр дүн: Зайны сургалтын системийг хөгжүүлэлтийг хийлгэсэн. Орон нутагт сургалтыг түргэн шуурхай зохион байгуулах боломжтой болсон, сургалт явуулахад гарах зардал багасгана. Хөл хорио болон бусад онцгой байдлын үед ч сургалтыг тасралтгүй явуулах боломжтой болно.

ҮЙЛ АЖИЛЛАГАА: 5.4: ДОНОР ХАНДИВЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭГ ӨРГӨТГӨХ, ШИНЭ ХАРИЛЦАГЧДЫГ БИЙ БОЛГОХ

ҮА: 5.4.1: ШИНЭЭР ЗАРЛАГДСАН БОЛОМЖИТ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДЭД ОРОЛЦОХ. БАЙГУУЛЛАГЫН ДОТООДОД ХЭРЭГЛЭХ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН МАСТЕР ЗАГВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ.

1. БРИТИШ КОЛУМБЫН ИХ СУРГУУЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД САНАЛ СОЛИЛЦСОН ТУХАЙ

Огноо: 2021/3/12-05.27

Үйл ажиллагаа: 2021 оны эхний хагаст энэхүү үүл ажиллагаатай холбогдуулан Герман-Монголын хамтарсан ашигт малтмалын технологийн их сургууль болон Бритиш Колумбын их сургуулиудтай хамтран ковидын үеийн нөлөөллийн судалгааг бичил уурхай эрхлэгч нөхөрлөлийн хүрээнд хийж гүйцэтгэж олон улсын болон дотоодын харилцагч түншлэлийн хүрээг өргөтгөж чадсан бөгөөд хамтын ажиллагааны үр дүнд дараа дараагийн 2 төсөл хөтөлбөрт баг болон ажлын саналыг илгээсэн.



- Мөн Швейцарын хөгжлийн агентлаг болон UNDP, Германы элчин сайдын яам зэрэг газруудын зарлагд- агсан нийт гурван төсөл хөтөлбөрт материал бэлтгэн

оролцсон. Ядуурлыг бууруулах амьжиргааны эх үүсвэрийг төрөлжүүлэх болон хүний эрхийн гэсэн 2 чиглэлээр төслийн баримт бичгийн мастер загварыг бэлтгэсэн. Цаашид дээрх 2 чиглэлээр зарлагдсан төсөл хөтөлбөрт хугацаа алдахгүй түргэн шуурхай оролцох боломжтой болсон. Мөн байгууллагын танилцуулах албан ёсны захидлын эхийг Гадаад харилцааны ажилтан Б.Назерке тэй хамтран боловсруулан олон улсын хүрээнд харилцагчдын хүрээг өргөтгөх зорилгоор дараах байгууллагад илгээсэн.

Үр дүн: 2021 оны эхний хагаст ний гурван төсөл хөтөлбөрт дангаараа материалаа илгээж оролцсон, нэг төсөлд олон улсын 2 байгууллагатай хамтран оролцсон. Төслийн 3 темплетийг бэлэн болгосон. Дараа дараагийн төсөлд тухайн чиглэлээр түргэн шуурхай оролцох боломжтой болсон.

Гадна болон дотнын томоохон 2 их сургуультай шинэ харилцаа үүсгэн хамтран ажиллаж эхэлсэн.


БҮТЭЭГДЭХҮҮН: 5-ИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ:

Огноо	ҮА	НИЙТ			ТАХ			БУ			БУСАД		
		Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм
01/03	5.1	7	5	2	0	0	0	3	1	2	4	4	0
04/16	5.2	2	2	0	0	0	0	1	1	0	1	1	0
00/00	5.3	3	3	0	0	0	0	2	1	1	1	0	1
03/12	5.4	6	3	3	0	0	0	2	1	1	4	2	2
#	Нийт	18	13	5	0	0	0	8	4	4	10	7	3

БҮТЭЭГДЭХҮҮН 5-ИЙН ДҮГНЭЛТ ХЭСЭГ:

- Байгууллагын тогтвортой байдлыг хангах, санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх үйл ажиллагаатай холбоотойгоор дээрх 4 ажлыг хийж хэрэгжүүлсэн бөгөөд дараах дүгнэлтэнд хүрсэн байна.
- Дээрх 4 ажлыг хийж хэрэгжүүлэх хүрээнд нийт 18 хүний оролцоотой үйл ажиллагааг хэрэгжүүлсэн ба үүнээс эрэгтэй 13, эмэгтэй 5 байсан.
- Дээрх ажлуудаас гарах үр дүнгийн хувьд байгууллагын цаашдын урсгал зардлыг багасгаж санхүүгийн болон үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах төдийгүй байгууллагын пассив хөрөнгийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж, хойшид төсөл хөтөлбөрт оролцох, хэрэгжүүлэх бааз суурийг бий болгон өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

БҮТЭЭГДЭХҮҮН-6: БАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭДЭХ АЖ АХУЙ, ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ



ҮЙЛ АЖИЛЛАГАА: 6.1: ХАБЭА-Н АЛБАН ЁСНЫ СУРГАЛТ ЯВУУЛАХ ЭРХ БҮХИЙ СУРГАЛТЫН ТӨВИЙГ АЖИЛЛУУЛАХ

ҮА: 6.1.1: СУРГАЛТЫН ТӨВ АЖИЛЛУУЛАХ БИЗНЕС ТӨСӨЛ БИЧИХ

1. ХАБЭА-ЫН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТАНХИМ БАЙГУУЛАГДЛАА

Огноо: 2021/03/03

Үйл ажиллагаа: Тус үйл ажиллагааны хүрээнд яамнаас тавьсан шаардлагын хүрээнд сургалтын танхимыг тохижуулан. Яамны гаргасан хөтөлбөрийн хүрээнд сургалтын иж бүрэн материалыг бэлэн болгосон .

- Ажлын удирдамжийг боловсруулан батлуулж түүний дагуу бизнес төлөвлөгөө боловсруулан бэлэн болгосон.

Үр дүн: Сургалт явуулах ажлын бэлтгэл үе шатыг хэрэгжүүлж шаардлагатай ажлууд хийгдэж дууссан. Мөн зайн сургалтын системийг хөгжүүлсэн. 7-р сард яамнаас зөвшөөрөл олгогдвол сургалтын төвийг нээнэ.

ҮЙЛ АЖИЛЛАГАА: 6.2: УУЛ УУРХАЙН ТОМООХОН КОМПАНИУДТАЙ ГУРВАЛ-САН ГЭРЭЭ БАЙГУУЛАН ХАМТРАН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ БОЛОМЖИЙГ СУДЛАХ.

ҮА: 6.2.1: БИЗНЕС ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ. Дотоодын томоохон уул уурхайн компаниудтай гурвал-сан гэрээ байгуулан хамтран ажиллах бизнес саналыг тавих, удирдлагуудтай уулзалт хийх.

1. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БИЧИЛ УУРХАЙН ЭВ НЭГДЛИЙН ХОЛБОО, МАРКО-ПОЛО КОМПАНИТАЙ ГУРВАЛСАН ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАХААР БОЛЛОО.

Огноо: 2021/05/15

Үйл ажиллагаа: Дээрх ажлын хүрээнд дотоодын томоохон уул уурхайн 3 компани болон гадны 3 компанид хандан хамтран ажиллах хүсэлт болгон байгууллагын таилцуулгыг бэлтгэн хүргүүлсэн. Мөн гишүүн байгууллагын өөрсдийн санаачилгаар Говь-алтай аймагт үйл ажиллагаа явуулж буй Уул уурхайн компанитай гурвалсан гэрээ байгуулах санал хүргүүлснээр хамтран ажиллах болсон.

- Алтайн бичил уурхайчдын холбоо Бигэр суман дахь тусгай зөвшөөрөл эзэмшигч Марко-поло компанитай гурвалсан гэрээгээр ажиллахаар, Бигэр сумын Засаг дарга хооронд гэрээ байгууллаа.
- Тус компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, тэдний хөдөлмөрлөх эрхийг хангахад дэмжлэг үзүүлэн бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын дагуу гэрээ байгуулахыг хүлээн зөвшөөрлөө. Алтайн бичил уурхайн эв нэгдлийн холбооны өмнөөс гэрээний талуудтай холбоо тогтоож, бичил уурхайн салбарын болон тус холбооны үйл ажиллагааны талаар эерэг мэдээлэл өгч, гэрээ байгуулахад МБУНДХ-ноос дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан юм.
- Говь-айлтай аймгийн удирдлагууд Алтайн бичил уурхайн эв нэгдлийн холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн аймгийн төвийн 2 давхар, 2 заал 6 өрөө бүхий объектыг тодорхойгүй хугацаагаар эзэмшилд өгч, тэднийг өөр ажлын байранд шилжих, нэмэлт орлоготой болох, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлэхэд томоохон дэмжлэг үзүүлсэн байна.
- Мөн 2020 оны 12 сард аймгийн ИТХ-р 2 газрыг бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэрийг гаргасан байна.
- Мөн аймаг хөгжүүлэх үндсэн чиглэл засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт бичил уурхайг дэмжүүлэх чиглэлийг тусгуулсан. Аймгийн засаг дарга болон цагдаагийн газартай хамтран ажиллах гэрээ байгуулахаар ажиллаж байна.

Үр дүн: Говь-алтай аймгийн хэмжээнд бичил уурхайчид санаа нэгдэн, хамтран ажиллаж, тэдний гаргасан санлыг орон нутаг зөвхөн аймгийн холбоогоор дамжуулан шийдвэрлэж байгаа нь эв нэгдлийг бий болгохын зэрэгцээ, иргэдийн хамтын хөдөлмөрийг дэмжсэн үйл явдал болж байна. Орон нутгийн удирдлагуудын хамтын ажиллагаа, ойлголцол сайн байгаа бөгөөд бичил уурхайчдыг өөр ажлын байранд шилжих, нэмэлт орлого олох арга замуудад дэмжлэг үзүүлэн ажлын байраар хангах үйл ажиллагааг дэмжиж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА: 6.3: ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ЭКСПОРТЫН СУДАЛГАА ХИЙХ

ҮА: 6.3.1: Үнэт эдлэлийг экспортлох бизнесийн суурь судалгаа хийх

1. ҮНЭТ МЕТАЛЛЫН ОЛБОРЛОХ, БОЛОВСРУУЛАХ, ХУДАЛДААЛАХ, ҮЙЛДВЭРЛЭХ, СОРЬЦЛОХ САЛБАРЫХАН НЭГДЭН ХОЛБОО БАЙГУУЛЛАА.

Огноо: 2021/01/01

Үйл ажиллагаа: Санхүүгийн зохицуулах хорооноос Санхүүгийн зохицуулах хорооны 2020 ны 03 дугаар сарын 25-ны өдрийн “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын дагуу 2020 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Үнэт металлын салбарын олборлох, боловсруулах, сорьц тогтоох, үйлдвэрлэх, худалдаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоодууд хамтран Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн үндэсний холбоо байгуулан хамтран ажиллаж байна.

- Иймд Үнэт металлын үндэсний холбоогоор дамжуулан үнэт металлын салбарт суурь судалгаа хийж, түүгээрээ дамжуулан экспортлох, олон улсын зах зээлд нэвтрүүлэх зэргээр ажиллаж байна.

Үр дүн: Бичил уурхайн салбар олборлох үйл ажиллагаанд оролцогч нөхөрлөлүүдийг хамруулан олборлох бодлогын зөвлөлд, хүдэр боловсруулагчдыг боловсруулах бодлогын зөвлөлд, алтны худалдаачдыг худалдаалах бодлогын зөвлөлд хамруулан ажиллаж байгаа нь салбарын тулгамдаж буй асуудлуудыг хамтдаа шийдвэрлэх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

БҮТЭЭГДЭХҮҮН: 6-ИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ:

Огноо	ҮА	НИЙТ			ТАХ			БУ			БУСАД		
		Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм
03/03	6.1	6	2	4	0	0	0	6	2	4	0	0	0
05/15	6.2	3	1	2	0	0	0	3	1	2	0	0	0
01/01	6.3	42	29	13	0	0	0	42	29	13	0	0	0
#	Нийт	51	32	19	0	0	0	51	32	19	0	0	0

БҮТЭЭГДЭХҮҮН 6-ИЙН ДҮГНЭЛТ ХЭСЭГ:

- Байгууллагын дэргэдэх аж ахуй, туслах үйлчилгээ бүтээгдэхүүн 6-ийн хүрээнд 3 үйл ажиллагаа төлөвлөсөн ба үүнтэй холбоотой хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд нийт 51 хүн оролцсон ба үүнээс-32 эрэгтэй, эмэгтэй-19 хүн хамрагдсан байна.
- Албан ёсны сургалт явуулах эрх авах ажлын хүрээнд хөдөлмөр нийгэм хамгааллын яамны шаардлагын дагуу анги танхим, сургалтын хэрэглэгдэхүүнээр бүрэн тохижуулсан энэхүү сургалтын төвөөр дамжуулан бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэд, нөхөрлөл хоршоодод дүрэм журмын хүрээнд аюул осолгүй орчинг бүрдүүлэн ажиллах боломжийг бий болгохын зэрэгцээ эдгээр нөхөрлөл, хоршоодыг хувь хүний хөгжил, хандлагыг өөрчлөх аргаар бэхжүүлэн, цаашид багаар ажиллах сайн дадал зуршлыг төлөвшүүлэх юм. Багын гишүүд хоорондоо тодорхой харьцах, бусдыгаа идэвхтэй сонсох, баг бүлгээр үр дүнтэй ажиллах, бие биенээ хайрлан халамжилж өөрсдийгөө хөгжүүлэх зан чанарыг дадал зуршил бий болгоход сургалт, сургалтын орчноор дамжуулан нөлөөлөх юм.

Гурвалсан гэрээгээр ажиллах энэхүү нөхцөлийг бичил уурхайн салбарын бизнесийн загвар модуль болгон хөгжүүлж салбарын шинэ жишгийг бий болгон бусад үндэсний томоохон уул уурхайн компани хандлагыг өөрчлөн салбарт эерэг нөлөөг бий боломж гэж харж байгаа. Иймд Говь-Алтай аймгийн холбоог бүхий л талаар дэмжин ажиллах болно.

- Үнэт металлын салбарын оролцогчдын хамрах хүрээг тогтоох суурь судалгааг Үнэт Металлын Холбооны санхүүжилтээр судалгааны 2 байгууллагатай хамтран хийж байгаа бөгөөд тооллого судалгааны үр дүнд үндэслэн салбарын зах зээлийн судалгааг хийнэ. Дээрх судалгаанаас салбарын баттай мэдээллийн эх үүсвэр бий болох бөгөөд энэ нь цаашдын төлөвлөсөн ажлыг хэрэгжүүлэхэд гадаад зах зээлд оролцох боломжийг олгоно гэж харж байгаа.

БҮТЭЭГДЭХҮҮН-8: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОСГОХ, ГАДААД БОЛОН ДОТООД ХАРИЛЦААГ ХӨГЖҮҮЛЭЛТ

ҮЙЛ АЖИЛЛАГАА:8.1: ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ, ӨРГӨЖҮҮЛЭХ

ҮА: 8.1.1: А) ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДАЙ ХОЛБООТОЙ ГАДААД ХАРИЛЦААНЫ ХҮСНЭГТ ХӨТӨЛЖ, ОНЛАЙН ХУРАЛ, МЭЙЛ ХАРИЛЦАА, МЭНДЧИЛГЭЭ, ТАЙЛАГНАЛ, АСУУМЖ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ТОГТМОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Б) БОЛОМЖИТ ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН СУДАЛГАА ХИЙЖ БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЭХ ЗОРИЛГОТОЙ МЭЙЛ БИЧИХ, ТАНИЛЦУУЛГА ХИЙХ, БИЕЧЛЭН БОЛОН ОНЛАЙН УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, МБУНДХ-Г СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ

1. ТРАФИГУРА САН

Огноо: 2021/01-06

Үйл ажиллагаа: Трафигура сан нь МБУНДХ-той 2019-2023 он хооронд хмтран ажиллах гэрээтэй бөгөөд 2021 оны хувьд хамгийн том санхүүжүүлэгч бөгөөд хамтын ажиллагаа амжилттай үргэлжилж байна. Энэхүү хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэх, үргэлжлүүлэхийн тулд дараах үйл ажиллагаануудыг өдөр тутамд, тогтмол хэрэгжүүлж байгаа юм. Үүнд:



- Өдөр тутмын цахим мэйлүүд болон ээлжит цахим хурал, хэлэлцээрүүд
- Мэдээ бэлдэх, тоо нэгтгэх

- 2021 оны 1,2-р улирлын үйл ажиллагааны тайлан
- 2020 оны санхүүгийн тайлан
- 2021 оны санхүүгийн тайлан
- 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

Үр дүн: Улирлын болон хагас жилийн тайлангууд болон явцын мэдээнүүдэд үндэслэж дараагийн санхүүжилтийн асуудал шийдэгддэг бөгөөд эхний тайлант жилийн хугацаа болох 2020.06 сараас 2021.05 сар хүртэлх хугацааны санхүүжилт 90%-ийн гүйцэтгэлтэй орсон. Одоогийн байдлаар хоёр дахь тайлант жилийн хугацаа болох 2021.06-2022.05 хооронд хийгдэх ажлуудын төлөвлөгөө болон санхүүжилтийг баталж, шийдвэрлэх шатанд явж байна.

2. ЛЕВИН СОУРСЭС

Огноо: 2021/01-06

Үйл ажиллагаа: МБУНДХ ТББ болон Трафикура сангийн хамтын ажиллагааны хүрээнд 2020 оны 8-р сараас 1 жилийн хугацаатайгаар Левин соурсэс компани нь зөвлөх үйлчилгээ үзүүлж хамтран ажиллаж байгаа юм. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэв:

- Тогтмол мэйлийн харилцаа, онлайн хурлууд
- МБУНДХ-нд тулгарч буй асуудлуудыг ярилцаж шийдэх, гарц олох
- Төсөл, хөтөлбөрүүд, шинэ цаг үеийн мэдээллүүд солилцох
- МБУНДХ-ы бренд бүхий албан бичиг баримтуудын өнгө загвар гаргасан
- Гүйцэтгэх албаны ажилчдын ажлын үр бүтээмжийг илүү их нэмэгдүүлэх, цагаа зөв зохистой хуваарилах зорилготойгоор RASCI хүснэгт хөтөлж эхэлсэн.

Үр дүн: МБУНДХ-ы ажилчид тус бүр зөвлөх үйлчилгээ авч, ажил албан үүрэгтээ ашиглаж, байгууллагын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой болсон. МБУНДХ-ны нөөцөнд тулгуурлаж зөвлөх үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зүгээс санаачлан гаргасан “Сургалтын төв” байгуулж, дээвэр холбооны санхүүгийн болон үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилготой ажил амжилттай хэрэгжиж байна.

3. АЗИЙН САН

Огноо: 2021/03/17

Үйл ажиллагаа: Азийн сан нь сайн засаглал, эдийн засгийн өсөлтийг дэмжих, байгаль орчныг хамгаалах, эмэгтэйчүүдийг чадавхжуулж, амьдралын чанарыг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус олон улсын хөгжлийн байгууллага юм.



- Азийн сан нь 2020-2022 оны хооронд “Хууль бус олборлолттой тэмцэх чадавхыг сайжруулах” төслийг АНУ-ын Төрийн департаментийн санхүүжилттэй хэрэгжүүлж байна. “Хууль бус олборлолттой тэмцэх чадавхыг сайжруулах” төсөл нь хуулийн салбарынхныг хууль бус олборлолтын холбогдолтойгоор чадавхийг сайжруулах, мөнгө угаах болон бусад холбогдолтой гэмт хэргүүдэд анхаарал хандуулах замаар Монгол улс дахь хууль бус олборлолтын гэмт хэргийг багасгах мөн засгийн газар болон парламенттай хамтран ажиллаж бодлогын шинэчлэлийг дэмжих зорилготой юм. Уг төсөл нь Ковид-19 цар тахлын удаа дараагийн хөл хорионы улмаас хугацаандаа хэрэгжиж эхэлж чадаагүй бөгөөд 2021 оны 1-р улирлын сүүлээр үйл ажиллагаагаа албан ёсоор эхэлсэн билээ.
- Уг төслийг хамтран хэрэгжүүлэх хүсэлтийг МБУНДХ ТББ-ы зүгээс өгч 2020 оны 10-р сараас хойш удаа дараа мэйлээр харилцаж, утсаар ярилцсан бөгөөд 2021 оны 3-р сарын 17-нд ZOOM-ээр 2 талын уулзалт хийв. Энэхүү төслийн хүрээнд хуулийн байгууллагын ажилчид, шүүгчид, цагдаа болон төрийн албан хаагчдыг сургалтанд хамруулах, ХАМО иргэдийг албажуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Азийн сан нь МБУНДХ-той хууль бус олборлолтын одоогийн нөхцөл байдал, энэ чиглэлээр хийгдэж байсан ажлууд, цаашдын чиг хандлага, бусад холбогдох мэдээллүүдийг авч хамтран ажиллахаар боллоо.
- 2020 оны санхүүгийн тайлан

Үр дүн: Азийн сан нь МБУНДХ-той цаашид хамтран ажиллах хүсэлтэй байгаа бөгөөд нээлтэй төслийн зар зарлахгүйгээр албан бичгээр (7-р сард) хамтран ажиллах хүсэлт явуулах бөгөөд МБУНДХ-ы зүгээс боловсруулсан ажил гүйцэтгэх төлөвлөгөө болон төслийн ажил гүйцэтгэх явцын үр дүнгээс хамаарч дараа дараагийн ажлуудаа хамтран хийх төлөвлөгөөтэй байгаагаа илэрхийллээ.

ҮЙЛ АЖИЛЛАГАА: 8.3: ОЛОН УЛСЫН ПЛАТФОРМУУДАД ЭЛСЭХ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ

ҮА: 8.3.1: а) Дэлхийн банк, SOLIDARIDAD, IMPACT, PDAC, IGF, OECD, ADB, FUNDSFORNGO, TWITTER, LINKEDIN БҮХИЙ ТОМ ХЭМЖЭЭНИЙ ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ АГУУЛСАН ПЛАТФОРМУУДАД БҮРТГҮҮЛЖ ТУХАЙ БҮР МЭДЭЭЛЭЛ АВЧ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ ЦАГ АЛДАЛГҮЙ АВАХ

б) ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН БҮРТГЭЛ БҮХИЙ ХҮСНЭГТ ХӨТӨЛЖ, ҮР ДҮНГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ ЭХ ҮҮСВЭР, ЦАГ ХУГАЦАА ХҮН ХҮЧИЙГ ЗӨВ ЗОХИСТОЙ ХУВААРИЛАХ.

в) ТӨСЛИЙН САНАЛ БОЛОВСРУУЛАХ ХУВИЛБАРУУД ХӨГЖҮҮЛЭХ

1. FUNDSFORNGO МЭДЭЭЛЛИЙН ВЭБСАЙТ

Огноо: 2021/01-06

Үйл ажиллагаа: Олон улсын төсөл хөтөлбөрийн мэдээллүүдийг цаг тухайд нь авах, улмаар төсөл боловсруулж санхүүжилт босгох зорилготойгоор 2021 онд бид FundsforNGO-ийн эрхийн хугацааг сунгасан юм.



Үр дүн: Энэхүү платформыг цаашид илүү сайн ашиглаж 2021 ондоо багтааж төслийн санал боловсруулж, санхүүжилт авах тал дээр ажиллах боломж нээлттэй хэвээр байна.

2. ZOOM ОНЛАЙН УУЛЗАЛТЫН ПЛАТФОРМ

Огноо: 2021/01-06

Үйл ажиллагаа: 2020 оны эхлээд Дэлхий даяар цар тахал газар авч бид бүхний амьдралын хэв маяг, ажиллах арга барилууд бүгд маш хурдтай өөрчлөгдсөн билээ.



- Маш урт хугацааны турш бид ажлаа цахим орчинд гүйцэтгэж, цахим орчинд уулзалт, хэлэлцээрүүд хийх шаардлага үүссэн учир бид онлайн уулзалтын Zoom платформыг ашиглаж эхэлсэн.

Үр дүн: Энэхүү платформ нь МБУНДХ-ы үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд маш том хувь нэмэр төрүүлсэн бөгөөд сургалтын үйл ажиллагаагаа цаг алдалгүй зохион байгуулах боломжийг олгосон.

МБУНДХ-ы гүйцэтгэх алба санхүүжилт босгож, үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилготой дараах төслийн саналуудыг боловсруулж явуулсан бөгөөд хамтран ажиллагч 23 байгууллагад хамтран ажиллах албан бичиг явуулсан:

	Төслийн нэр	Зарласан байгууллага	Хугацаа	Хамтран оролцогч байгууллага	Төсөлд шалгарсан эсэх
1	Бичил уурхайн салбар ба Ковид-19 цар тахлын нөлөөллийг судлах	Дэлхийн банк	2021.05	SKAT foundation	Тэнцээгүй
2	Бичил уурхайн салбар ба Ковид-19 цар тахлын нөлөөллийг судлах	Дэлхийн банк	2021.05	The Queensland University	Тэнцсэн

3	Бичил уурхайн салбар дахь хүүхэд, залуучуудын чадавхийг сайжруулах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар амьдралын чанарыг нь сайжруулах	Канадын сан	2021.08	German-Mongolian Institute for Resources and Technology (GMIT); The University of British Columbia	Хариу гараагүй
4	Бичил уурхайн салбар ба Ковид-19 цар тахлын нөлөөллийн судалгаа	Дэлхийн банк	2021.08	The British Columbian University, German-Mongolian Institute for Resources and Technology	Хариу гараагүй
5	Орон нутаг дахь халуун усны хүртээмжийг нэмэгдүүлж, орон нутагт шинэ ажлын байр бий болгох	Канадын сан	2021.08	Говь-Алтай аймгийн холбоо	Хариу гараагүй

2021 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮГНЭЛТ ХУРААНГУЙ ХЭСЭГ:

2021 оны 6 дугаар сарын байдлаар дээрх үйл ажиллагаануудыг хийж хэрэгжүүлэхэд нийт хамрагдсан тоон үзүүлэлтийг графикаар харуулав. Хүснэгт-1:

2020 оноос 2021 оны эхний хагаст буюу өнөөг хүртэл цар тахлын нөхцөл байдал бичил уурхайн салбарын төдийгүй Монгол улс, Дэлхий нийтийн хувьд саад бэрхшээлийн даван туулсан, тэмцсэн, ялсан, ялагдсан түүх он цаг байлаа.


МБУНДХ 2021 онд Бичил уурхайн салбарын хууль эрх зүйн орчны шинэчлэлтийн ажлыг төрийн байгууллагуудтай хамтран эхлүүлсэн, цар тахлын нөлөөллийн хүнд үед бичил уурхайчдын дуу хоолой болсон үндэсний холбооны тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан, гүйцэтгэх албаны ажилтан ажиллагсад болон хүнд цаг үед бидэнтэй хамт байсан донор байгууллагууд тэр дундаа Trafigura сан, дэлхийн зөн зэрэг байгууллагууд та бүгдэд гүн талархлаа илэрхийлж байна. Бид өнгөрсөн хагас жилийн хугацаанд үндэсний болон олон улсын хэмжээнд салбарын оролцогчдын нийтлэг эрх ашгийг хамгаалах, тэдгээрийг тогтвортой ажлын байртай, орлоготой, байгаль орчны болон нийгмийн хариуцлагатай бичил уурхайчин, бизнес эрхлэх боломжийг илүү нээлттэй болгож өгөх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох улмаар тэдний амьдралын чанарыг дээшлүүлэх эрхэм зорилготойгоор үйл ажиллагаагаа явууллаа.

1. Бичил уурхайн салбарын өнөөгийн бүтэц зохион байгуулалтыг цаашид удаан хугацаанд тогтвортой байснаар оролцогсдын эрх ашиг, улс орны хөгжил дэвшилд томоохон хувь нэмэртэй билээ. Иймд Дээвэр Холбооны хүний нөөцийн тогтвортой, мэргэшсэн байдал, ажлын үр дүн маш чухал. Гүйцэтгэх алба, сургагч багш нарыг чадваржуулах, сургалтын төрөл, хүрээгээ нэмэгдүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн ажилласаар байна. Чадваржуулсан хүний нөөц дээрээ тулгуурлан 2021 онд ХАБЭА-н албан ёсны сургалтын эрхийг авах ажлыг эхлүүлэн явцын гүйцэтгэл 70 % тай байна, Дэлхийн Зөн ОУ ын байгууллагатай БЭБХ сургалтыг орон нутагт зохион байгуулах 3 жилийн хугацаатай гэрээ байгуулан ажиллаж эхлээд байгаа. Цаашид албан ёсны сургалт явуулах эрхтэй болсноор байгууллагын тогтвортой үйл ажиллагаа явуулах боломж бүрдэж салбарын зохион байгуулалттай тогтвортой байдалд эерэг нөлөө бий болно.
2. Мөн гишүүдийн идэвх-ий оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд мэдээлэл, сургалтыг тасралтгүй хүргэх чиглэлт анхаарал хандуулан дараах ажлыг эхлүүлээд байгаа билээ. Үүнд: Бичил уурхайн мэдээлэл, нөлөөллийн ажлыг цахим сайтаар дамжуулан хүргэх, байгууллагын өөрийн эзэмшлийн веб, сервертэй болон цахим сургалтын платформыг хөгжүүлэн ажиллаж байна. Энэ нь гишүүдийн тасралтгүй суралцах боломжийг олгохоос гадна дээвэр холбооны тухайн үйл ажиллагаатай холбоотой гарах зардлыг багасгах сайн талтай. МБУНДХ-ны сургалт үйлчилгээг цаашид илүү хүртээмжтэй, тасралтгүй байх үндсэн боломжийг бүрдүүлэн ажилласан.
3. Төрийн байгууллагуудын МБУНДХолбоог үнэлэх үнэлэмж өссөөр байгаа төдийгүй энэ хагас жилийн хугацаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин аялал жуулчлалын яам, Экологийн цагдаагийн алба зэрэг байгууллагууд хамтын ажиллагааг хөгжүүлэн, салбарын мэдээ мэдээллийг харилцан солилцож ажилласан. УУХҮ яам, ашигт малтмалын газартай хамтран Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох 151-р журмыг шинэчлэн өөрчлөх төслийн ажлын хэсэгт орон ажилласан.
4. Санхүүжилтийн эх үүсвэр тогтвортой болгох чиглэлд өнгөрсөн хагас жилийн хугацаанд төслийн баримт бичгийн 4 загварыг бий болгон нийт 7 төсөл хөтөлбөрт материал илгээн оролцсоноос 1 төслийн анхан шатанд тэнцсэн байгаа. Мөн байгууллагын цахим сайтыг хандалтыг нэмэгдүүлж санхүүжилт босгох боломжтой плафрутд холбохоор бэлтгэл ажил хийгдэж байна.
5. Гадаад харилцаа, хамтын ажиллагаанд нийлээд өөдрөг дүр зураг бий болсон. Өнгөрсөн хагас жилийн хугацаанд 25 ОУ-н байгууллагатай хамтран ажиллах санал хүргүүлж 4 байгууллагаас нааштай хариу авсан. Мөн гадаадын 1 их сургууль, дотоодын 1 их сургуультай хамтын ажиллагаа хөгжүүлэх амжилттай холбоо тогтон ажиллаж байна. Нийт 26 байгууллагад хамтран ажиллах санал хүргүүлж, 7-н төсөл хөтөлбөрт оролцсон төдийгүй ОУ чанартай цахим хурал, уулзалтууд байнга оролцож байгаа.
6. Бичил уурхайн хууль эрх зүйн баримт бичиг өөрчлөлт орсноор МБУНДХ-оос нийт салбарын оролцогчдоо таниулах, мэдээлэх ажлын бэлтгэлийг ханган ажиллаж, үүнтэй холбоотой төсөв зардлыг боловсруулан хамтран ажиллах байгууллагад хүргүүлэн нааштай хариу авсан байгааг дуулгахад таатай байна. Мөн Говь-Алтай аймгийн холбоо үндэсний уул уурхайн томоохон компанитай гурвалсан гэрээ байгуулан нь энэ хүнд цаг үед салбарын өнгө төрхийг илэрхийлэх

бизнес загвар болсон төдийгүй бусад аймгийн холбоо, нөхөрлөл, хоршоодод албан ёсны зохион байгуулалтын сайн үр дүнг биетээр харуулсан сайн жишиг болж чадсан онцлох үйл ажиллагаа байлаа.

7. МБУНДХ өөрийн өмчлөлийн байртай болсон нь байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдал хангагдахад чухал алхам, амжилт байлаа.

ТАЙЛАНГИЙН ХУГАЦААНЫ ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДЫН НЭГДСЭН ТООН МЭДЭЭЛЭЛ:



БЭЛТГЭСЭН

Хэрэгжүүлэгч байгууллага:	Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо	
Байгууллагын вэб сайт:	http://bichiluurhai.mn/news/	
Ажлын утас:	976- 7015-5959	
Тайланг нэгтгэсэн:		Р.Түмэндэмбэрэл, Сургалт, судалгаа хөгжлийн мэргэжилтэн
Тайланг гадаад хэлнээ хөрвүүлсэн.		Н.Назерке, Гадаад харилцаа хөрөнгө оруулалтын мэргэжилтэн
Тайлан бэлтгэсэн		Н.Цэнд-аюуш, Бизнес хөгжлийн мэргэжилтэн
Тайлан бэлтгэсэн:		Р.Түмэндэмбэрэл, Сургалт, судалгаа хөгжлийн мэргэжилтэн
Тайлан бэлтгэсэн:		Г.Адьяаням, Санхүү нягтлан бодогч
Баталсан:		Н.Цэнд-аюуш, Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

